

**Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Газар**

**Ядуурлын Судалгааны Нэгж**

**Project: MON/01/U01**

*Судалгааны тайлан*

# **Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ**

Боловсруулсан:

**Г.Жаргал  
Ё.Отгонболд  
Ц.Батсүх  
С.Зүльфикар  
О.Одбаяр**

Зөвлөх:

**Ричард Маршал, НҮБХХ, ЯСН  
Ш.Мөнхцэрэн, СЭЗЯ, ЯСН**

**Улаанбаатар хот**

**2003 он**

## **Товчоолсон үг**

НҮБ	- Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
АОУХА	- Америкийн Олон Улсын Хамтын Ажиллагаа
ДБ	- Дэлхийн Банк
АХБ	- Азийн Хөгжлийн Банк
МУ	- Монгол Улс
ЗГ	- Засгийн Газар
ИХТ	- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	- Засаг Даргын Тамгийн Газар
ЯСН	- Ядуурлын Судалгааны Нэгж
СЭЗЯ	- Санхүү Эдийн Засгийн Яам
ҮХЯ	- Үйлдвэр Худалдааны Яам
ХХААЯ	- Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам
УА	- Удирдлагын Академи
ХААИС	- Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ЭТС	- Экологи Технологийн Сургууль
СЭЗДС	- Санхүү Эдийн Засгийн Сургууль
ХҮДС	- Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль
ТМС	- Техник мэргэжлийн сургууль
ББСБ	- Банк Бус Санхүүгийн Байгууллага
ХК	- Хувьцаат Компани
ХХК	- Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ХЗХ	- Хадгаламж Зээлийн Хоршоо
ХБХЗХ	- Хангамж Борлуулалт Хадгаламж Зээлийн Хоршоо
ХАСБанк	- Хөгжлийн Алтан Сан Банк
ХААН Банк	- Хөдөө Аж Ахуйн Банк
ХОНСҮХ	- Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэх
ХОНСТ	- Хөдөө Орон Нутгийн Санхүүгийн Төсөл
ХААСХТ	- Хөдөө Аж Ахуйн Салбарын Хөгжлийн Төсөл
ХААХҮХ	- Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоо
ГС	- Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага төсөл
МГТЭ	- Малын гаралтай түүхий эд
ХӨХБ	- Хүнс, өргөн хэрэглээний бараа
ХНХ	- Хувь нийлүүлсэн хөрөнгө

## Танилцуулга

<i>Төслийн нэр:</i>	Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ
<i>Төслийн зорилго:</i>	Малчдын хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх оновчтой арга замыг илрүүлэх
<i>Захиалагч:</i>	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Газар, Ядуурлын Судалгааны Нэгж, "МОН/01/Ю01/" төсөл
<i>Гүйцэтгэгч:</i>	Сургалт, судалгаа, төсөл боловсруулах Цаг-Тоо ХХК, МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын Академи болон СЭЗДС-ийн эрдэмтэн судлаачид
<i>Холбоо барих</i>	342270, 342073, 311359, 99176865 <a href="mailto:jargal_g@yahoo.com">jargal_g@yahoo.com</a> <a href="mailto:tsag_too@magicnet.mn">tsag_too@magicnet.mn</a>

### Судалгааны багийн танилцуулга

<i>Гүррагчаагийн Жаргал</i>	МУ-ын ЗГ-ын УА-ийн Удирдахуйн ухааны тэнхмийн багш, Удирдахуйн ухааны докторант, Төслийн удирдагч
<i>Ёндоншаравын Отгонболд</i>	Цаг-Тоо ХХК-ийн судлаач, Магистр
<i>Цэрэндоржийн Батсүх</i>	СЭЗДС-ийн Экономикс, экономертиксийн тэнхмийн эрхлэгч, доктор (Ph)
<i>Саркытын Зүльфикар</i>	МУ-ын ЗГ-ын УА-ийн Нийгмийн ухааны тэнхмийн багш, Удирдахуйн ухааны докторант
<i>Очирсүрэнгийн Одбаяр</i>	Цаг-Тоо ХХК-ийн судлаач, Бизнесийн эдийн засагч

## Гарчиг

<b>Бүлэг I. Танилцуулга</b>	
I.1 Танилцуулга	5
I.2 Судалгааны ажлын гүйцэтгэл	6
<b>Бүлэг II. Судалгааны арга зүй</b>	
II.1 Судалгааны онцлог, аргын хослол	8
II.2 Судлах зүйлийн хүрээ, үндсэн ойлголтууд	9
II.3 Түүврийн сонголт ба хэмжээ	12
<b>Бүлэг III. Судалгааны шинжилгээний үр дүн</b>	
<b>III.1 Өнөөгийн малчдын төлөв байдал</b>	
III.1.1 Малчин өрхийн ам бүл, боловсрол	14
III.1.2 Малчдын мэдээлэлийн суваг	15
<b>III.2 Малчин өрхийн хөрөнгийн бүтэцд хийсэн үнэлгээ</b>	
III.2.1 Малын төрөл малын бүтэц	16
III.2.2 Малчин өрхийн техник хэрэгсэл	19
III.2.3 Малчин өрхийн үл хөдлөх хөрөнгө	20
<b>III.3 Малчдын хөрөнгийн эргэлтэнд хийсэн үнэлгээ</b>	
III.3.1 Нийлүүлэлт борлуулалтын суваг	21
III.3.2 Малчин өрхийн орлого, зарлага	25
III.3.3 Амьжиргааны түвшингийн ангилал	28
III.3.4 Хөрөнгөө эргэлтэнд оруулах сэтгэлгээ	30
<b>III.4 Хамтран ажиллах арга ажиллагаанд хийсэн үнэлгээ</b>	
III.4.1 Хамтран ажиллах хэрэгцээ шаардлага	31
III.4.2 Хөдөөгийн хоршооны хэлбэр, онцлог	36
III.4.3 Хоршооны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ	39
<b>III.5 Малчдын зээлийн хэрэгцээнд хийсэн үнэлгээ</b>	
III.5.1 Малчдын зээлийн хэрэгцээ, зориулалт, хэмжээ, хугацаа, барьцаа хөрөнгө,	41
III.5.2 Хөдөөгийн бичил санхүүгийн үйлчилгээ	48
<b>Бүлэг IV. Дүгнэлт, Зөвлөмж</b>	
<b>IV.1 Нэгдсэн дүгнэлт</b>	53
<b>IV.2 Бодлогын зөвлөмж</b>	
IV.2.1 Сумын эдийн засгийг хөгжүүлэх стратегийн Хувилбарууд	57
IV.2.2 Хангамж борлуулалт Хадгаламж зээлийн хоршоог хөгжүүлэх талаар	60
<b>IV.3 Хэрэгжүүлэх зөвлөмж</b>	
IV.3.1 Малчдын сургалтын хэрэгцээг нарийвчлан тогтоож, сургалт зохион байгуулах	62
IV.3.2 Сум, багийн удирдах ажилтанууд эдийн засгийн мэдлэг олгох сургалтын агуулга	64

### Хавсралтууд

Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн  
Газар, "МОН/01/Ю01/" төсөл

Сургалт, судалгаа, төсөл  
боловсруулах Цаг-Тоо ХХК

**Хүснэгтийн индекс**

№	Нэр	Хуудас
1	Судлах зүйл, түүний шалгуур үзүүлэлт	10
2	Судалгааны аргууд	11
3	Малчдын боловсрол, хүйсийн харьцаа	12
4	Малчдын боловсрол, насны харьцаа	13
5	Малчин өрхийн малын бүтэц	16
6	МГТЭ-ийн нийлүүлэлт, ХӨХБ-ны борлуулалтын суваг	21
7	МГТЭ-ийн гарцын хэмжээ, үнэ	23
8	Малчин өрхийн орлогын тооцоо /жишээ/	23
9	Малчин өрхийн зарлагын тооцоо /жишээ/	25
10	Малчдын хорших хэлбэр, амьжиргааны түвшин	30
11	Амьжиргааны түвшингийн харьцуулалт	31
12	Хоршооны талаарх үнэлгээ	33
13	Зээлийн хэмжээ, зориулалтын харьцаа	43
14	Зээлийн хугацаа, зориулалтын харьцаа	44
15	Малчдын зээлийн хугацаа, хэмжээний харьцаа	44
16	Хөдөөгийн санхүүгийн үйлчилгээний байдал	46
17	Сумдад олгосон зээл	47
18	Хөдөөгийн хөгжлийн хувилбар	54

**Графикийн индекс**

№	Нэр	Хуудас
1	Малчдын боловсролын түвшин	13
2	Үхэртэй өрхийн тоо	14
3	Адуутай өрхийн тоо	14
4	Тэмээтэй өрхийн тоо	15
5	Хоньтой өрхийн тоо	15
6	Ямаатай өрхийн тоо	16
7	Малчин өрхийн машин техник	17
8	Малчин өрхийн үл хөдлөх хөрөнгө	18
9	МГТЭ-ийн борлуулалтын суваг	20
10	ХӨХБ-ны нийлүүлэлтийн суваг	20
11	Хоршин ажиллах хэлбэрүүд	29
12	Малчдын зээлийн зориулалт хэрэгцээ	39
13	Малчдын зээлийн хэмжээ	40
14	Малчдын зээлийн хугацаа	40
15	Малчдын зээлийн барьцаа хөрөнгө	41
16	Банкнаас зээл авсан малчид	41
17	Зээлийн нөхцөл	42
18	Малчдын сургалтын хэрэгцээ	59

**Хавсралт**

№	Нэр
1	Өвөрхангай, Говь-Алтай аймгийн хоршоод
2	ХААН, ХАС Банкуудын "Малчны зээл"
3	Өвөрхангай аймгийн Хархорин, Зүүнбаян-Улаан, Төгрөг сумдын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
4	Хөрөнгөө эдийн засгийн эргэлтэнд оруулж байгаа малчдын туршлага

## I бүлэг. ТАНИЛЦУУЛГА

### I.1 Танилцуулга

#### Зорилтууд

I.1.1 Малчдын орлогыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгөтэй болгох, мөнгөн хуримтлал үүсгэх, орон нутгийн нөхцөлд тохирсон дэвшилтэт аргуудад үнэлгээ өгөх зорилгыг хэрэгжүүлэхдээ дараахь зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- a) Малчдын өнөөгийн үйлдвэрлэл эрхлэлтийн байдлыг шинжлэх,
- b) Малчдын бүтээмжийг нэмэгдүүлэхэд шаардагдах биет хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх боломжит арга механизмуудыг үнэлэх,
- c) Хоршоо, нөхөрлөл байгуулах замаар малчид хамтран ажиллаж болох арга замуудад үнэлгээ өгөх,
- d) Малчид үйлдвэрлэлээ төрөлжүүлж болох арга ажиллагааг судлах,
- e) Малчдын зан заншил, сонголтонд нөлөөлж болохуйц нийгмийн бусад хүчин зүйл, малчдын сэтгэлгээний хандлагыг шинжлэх
- f) Богино, урт хугацаанд хэрэгжүүлж болох үр ашигтай, практикт ойр бодлогын зөвлөмжүүдийг боловсруулах.

#### Судалгааны хамрах хүрээ

I.1.2 Монгол орны мал аж ахуй давамгайлсан сумдад амьдарч байгаа малчин өрхүүдийг сонгон судална. Нэвтрүүлж, хэрэгжүүлж болох олон улсын туршлагаас малчдад санал болгох. Үүнд:

- a) Зээл авах боломжийг бүрдүүлэх, эргэлтийн сангийн ач холбогдол
- b) Хоршоо, нөхөрлөлийн үйл ажиллагаа
- c) Малчдын өөрсдийн хандлага, туршлага

#### Судалгааны арга зүй

##### I.1.3 Судалгааны үе шат

- a. Засгийн газар болон Олон улсын хандивлагч, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж болон бусад мэдээлэл, аргачлалыг судална.
- b. Тодорхой нөхцөл байдалд үнэлгээ шинжилгээ хийсэн баримт жишээ.
- c. Малчны үйлчилгээ болон малчны хамтын ажиллагаанд үнэлгээ өгч, цаашид хэрэгжүүлэх арга замын зөвлөмж боловсруулах
- d. Бодитой үнэн зөв мэдээлэлд суурилсан шинжилгээ
- e. Цаашид хэрэгжүүлж болох бодлогын зөвлөмжүүд (Хоршоолол, санхүүгийн үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний зах зээл, сургалт)

#### Үр дүн

##### I.1.4 Үнэлгээ судалгааны үр дүнд

- a. Баталгаа үндэслэлтэй бодит санаа, дүгнэлт
- b. Бодлогын болон хэрэгжүүлэх зөвлөмж.

## **I.2 Судалгааны ажлын гүйцэтгэл**

I.2.1 Гэрээний дагуу НҮБ-ийн Зөвлөх, ЯСН-ийн мэргэжилтэнтэй зөвлөж баталсан судалгааны үе шат тус бүрт хийж гүйцэтгэсэн ажил.

### **I үе шат: Судалгааны төлөвлөгөө**

I.2.2 Тус судалгааны агуулга нь зах зээлийн харилцаанд малчдын хөрөнгийн ашиглалт өгөөжийг нэмэгдүүлж, орон нутгийг эдийн засгийн талаас удирдах асуудал юм. Ийм судалгааны ажил нь урьд төдийлөн хийгдэж байгаагүй, харьцангуй шинэлэг тул судлах зүйл, судлагдахуун, арга зүйн хувьд шинэ арга ажиллагаа шаардагдсан.

I.2.3 Судлах зүйлийн хамрах хүрээ, судалгааны үе шатуудад хийх ажлын талаар НҮБ-ийн ХХ, СЭЗЯ-ийн ЯСН-ийн зөвлөхүүдтэй хэлэлцэн Судалгааны хөтөлбөрөө шинэчлэн боловсруулав.

### **I.2.4 Боловсруулсан ажлууд**

1. Судалгааны арга зүй, аргачлал
2. Судалгааны хүрээнд судлах зүйл, түүний үзүүлэлтүүд
3. Судлах зүйлийн тодорхойлолтууд
4. Мэдээлэл цуглуулах аргачлал
5. Малчдаас авах санал асуулга /тандалтын судалгаа/
6. Сумын бичил орчны хүчин зүйлийн судалгаа, оношлогоо

### **II үе шат: Өнөөгийн төлөв байдлын үнэлгээ**

I.2.5 Мал аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалтын өнөөгийн байдлын тухай малчдаас санал асуулга авах, мэдээлэл цуглуулах, эрдэмтэд, судлаачдын бүтээлүүдийн жагсаалт, сан боловсруулах зорилт дэвшүүлэн ажиллав.

### **I.2.6 Боловсруулсан ажлууд:**

1. Өвөрхангай аймгийн Есөнзүйл суманд явуулсан тандалтын судалгааны санал асуулгад SPSS программаар дан болон хоёрлосон бодолт хийж, урьдчилсан дүгнэлт хийв.
2. Санал асуулга, сурвалжлагын асуултуудад дүн шинжилгээ хийж, малчдад ойлгомжтой энгийн үгээр найруулах, асуултын тавилтыг өөрчлөх зэргээр асуулга, сурвалжлагыг сайжруулах ажлыг гүйцэтгэлээ.

### **III үе шат: Мэдээлэл цуглуулах**

I.2.7 Нийт 1000 респондентоос судалгаа авахаар төлөвлөсний 60%-ийг авч, үүний зэрэгцээ малчдаас авсан судалгаа нь эцсийн зорилгод хангалттай мэдээлэл болж чадахгүйг анхаарч, сумын удирдах ажилтан, ЗДТГ-ын 65 дарга нараас нэмэлт судалгаа авч боловсруулалт хийлээ.

I.2.8 Учир нь, Малчдаас авч байгаа судалгаанд малчдын хөрөнгө, малчдын эдийн засгийн сэтгэлгээний өнөөгийн төлөв байдал тодорхойлогдож, харин малчид хөрөнгөө эдийн засгийн эргэлтэнд оруулах санаа болон арга механизмын тухай төдийлөн илрэхгүй байсантай холбоотой юм.

### **1.2.9 Боловсруулсан баримт бичгүүд**

1. Орон нутгийн удирдах ажилтнуудаас авсан нэмэлт судалгааны санал асуулганд хийсэн дүгнэлт /дан болон харьцуулсан бодолтоор/
2. Бодлогын зөвлөмжинд дэвшүүлэх асуудалд: Хөдөөгийн хөгжлийн талаар баримтлах стратегийн хувилбарууд

### **IV үе шат: Шинжилгээ**

**1.2.10** Мал аж ахуйн үйлдвэрлэл, нийлүүлэлт борлуулалт, санхүү, хоршооны тухай санал асуулгыг дуусгах, авсан мэдээлэлд боловсруулалт хийх нь энэ үе шатны гол зорилт байлаа.

Энэ үе шатанд нийт 1000 санал асуулгын хариултаа SPSS-д нэгтгэн боловсруулах, төлөвлөсөн аргачлалын дагуу бүлэглэх талаар илүү анхаарч ажиллалаа.

### **1.2.11 Боловсруулсан баримт бичгүүд**

1. Санал асуулгын судалгаа үнэлгээний үндсэн үзүүлэлтүүд
2. Малчин өрхийн хөрөнгийн бүтцэнд хийсэн судалгаа
3. Малчдын нийлүүлэлт, борлуулалтын сувгийн төлөв байдал
4. Малчдын мэдээллийн суваг, сургалтын хэрэгцээнд хийсэн судалгаа
5. Малчдын эдийн засгийн сэтгэлгээ ба хөрөнгийн эргэлтийн талаарх санал, санаачилга
6. Малчдын зээлийн талаарх судалгаа
7. Малчдын хоршооны талаарх судалгаа
8. Орон нутгийн захиргаа ба иргэдийн оролцоо

### **Ү үе шат: Хөгжлийн зөвлөмж боловсруулах**

**1.2.12** Бодлогын зөвлөмж боловсруулах. Өнөөгийн шийдвэрлэж байгаа арга замууд, хувилбаруудыг дүгнэв /Хоршоолол, зээл олголт, банкны үйлчилгээ, сургалт, боловсрол олгох/

**1.2.13** Судалгааны ажлын явц, дэвшүүлж байгаа санал, дүгнэлтийг урьдчилсан байдлаар НҮБ-ийн ХХ, СЭЗЯ-ны ЯСНэгж, ҮХЯ, ХХААЯ, ХААН Банк, ХАС Банк, ХААИС-ийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдад танилцуулан хэлэлцүүлж, зөвлөлгөө авав.

### **1.2.14 Боловсруулсан баримт бичиг**

Судалгааны ажлын нэгдсэн тайлан

\* \* \*



## Бүлэг II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### II.1 Судалгааны онцлог, аргын хослол

II.1.1 Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ нь судалгааны шинэ асуудал мөн. Учир нь:

1. Малчид зах зээлийн харилцаанд аж ахуйгаа эдийн засгийн аргаар удирдан нэмүү өртөг бий болгож, ахуй амьдралаа дээшлүүлэн, эдийн засгийн хуримтлал үүсгэж хөгжүүлэх арга замыг эрэлхийлэх болсон,
2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлснээр эдийн засагт эргэлдэж байгаа хөрөнгийг зохистойгоор ашиглах арга боломжийг тодорхойлох хэрэгцээ үүсч байна.

II.1.2 Эдгээр хэрэгцээг хангах нийгэм, эдийн засаг, маркетингийн хүрээний асуудлуудыг хамруулсан өргөн хүрээтэй судалгаа юм.

II.1.3 Малчид, малчдын хөрөнгө, мал аж ахуйн бизнес гэсэн үндсэн ойлголтуудыг системийн аргаар авч үзвэл малчдын нийгмийн асуудал, малчин өрхийн эдийн засаг, мал аж ахуйн үйлдвэрлэл борлуулалт гэсэн гурван хүрээний асуудал тул эдгээрийг ангилан үзэхийн зэрэгцээ уулзвар огтолцолд нь судлах шаардлага үүсч байна.

II.1.4 Макро эдийн засгийн онолын үүднээс авч үзвэл малчин өрх нь нэгэн зэрэг үйлдвэрлэгч, хэрэглэгч болж байгаагаараа онцлог юм. Иймээс судалгааны ажлыг хэрэгжүүлэхдээ социологи, маркетинг, эдийн засгийн судалгааны аргуудыг хослуулан хэрэглэх шаардлагатай болсон. Тухайлбал:

**А.** Хөдөө, орон нутгийн малчдын нийгмийн сэтгэл зүйн өөрчлөлт, зах зээлийн харилцаанд суралцаж буй болон мал аж ахуйн бизнесийг эрчимжүүлэх, шинэчлэхтэй холбогдсон судалгаанд социологийн судалгааны аргыг баримтлах,

**Б.** Сум орон нутгийн эдийн засгийн боломж, зах зээлийн бүтцийг нөхцөл байдлын судалгааны аргад тулгуурлан судлах,

**В.** Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэлэг арга ажиллагааг илрүүлэх, малчдын бодол санаагаар баяжуулах асуудлыг судлахад маркетингийн судалгааны аргуудыг хэрэглэнэ.

Дээрх гурван төрлийн судалгааны аргуудаар **“малчин, малчны бизнес”** гэсэн ухагдахууныг тал бүрээс судалж, үр дүнг нь нэгтгэн боловсруулж, хоорондын уялдаа шүтэлцээг тодруулах явдал энэ судалгааны аргын онцлог болно.

II.1.5 Судалгааны аргуудыг хослуулан хэрэглэж байгаа тул судалгааны үндэслэл, зорилго, зорилтуудыг томъёолж, зорилт тус бүрийн судлах асуудлын задаргаа тайлбарыг боловсруулав. Судлах асуудал бүрт малчны болон сумын эдийн засаг, нийгмийн сэтгэлгээний хандлагыг илэрхийлэх хүчин зүйл, энэ асуудлын агуулгыг тодруулан үнэлэх хүрээг тодорхойлсон. Үүнд үндэслэж судалгааг явуулах хэлбэр, судалгааны аргачлалыг боловсрууллаа.

## **II.2 Судлах зүйлийн хүрээ, үндсэн ойлголтууд**

### **II.2.1** Судалгааны ажлын үндсэн судлах зүйл нь:

1. Малчин өрх, хөрөнгө
2. Мал аж ахуйн хамтын бизнес

### **Судлах зүйлийн хүрээ ба хэмжигдэхүүний тухай ойлголт:**

**II.2.2 Малчин өрх:** Өрхийн ам бүл, малчны боловсрол, зах зээлийн талаархи мэдлэг, малчдын суралцах хэрэгцээ.

**II.2.3 Малчны хөрөнгө:** а) Малчин өрхийн мөнгөн хөрөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт, бараа бүтээгдэхүүн зэрэг эргэлтийн хөрөнгө, б) мал сүрэг, с) өвөлжөө, хаваржаа, бэлчээр, барилга, машин техник, үйлдвэрлэлийн хэрэгсэл зэрэг хөдлөх хөрөнгө болон биет хөрөнгө.

**II.2.4 Мал аж ахуйн хамтын бизнес:** Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, малчин өрхийн хэрэглээ, борлуулалт нийлүүлэлтийн суваг, малчин өрхийн орлого, зарлага, хоршин ажиллах арга. Малчдын орлогыг нэмэгдүүлэх арга боломжууд.

**II.2.5 Хоршоолол, хоршоо:** Малчдын хорших сэтгэл зүйн урьдчилсан болон өнөөгийн нөхцлүүд, хоршооны болон хоршиж байгаа үйл явц. Хоршооны хөгжил, хоршооны төлөвшил амжилт, сургамж, цаашдын хандлага, мөн хорших дэвшилтэт арга.

**II.2.6 Зээл болон Санхүүгийн үйлчилгээ:** Малчид, мал аж ахуйн бизнес эрхлэгчдийг дэмжсэн зээлийн бодлого, зээлийн ашиглалтын талаархи мэдлэг чадвар, хөрөнгөө арвижуулахад зээлийг ашиглах мэдлэг, туршлага.

**II.2.7** Байгууллагын орчны онолоор малчин, малчны хөрөнгө, мал аж ахуйн бизнес гэсэн гурван ойлголтыг нэгтгэн авч үзвэл сум орон нутгийн бичил орчноос эдгээрт нөлөөлөх хүчин зүйлүүд ижил төсөөтэй байна.

**II.2.8** Суманд болон малчдад гадаад орчноос нөлөөлөх улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, олон улс зэрэг дам нөлөөлөл, хэрэглэгч, нийлүүлэгч, өмчлөгч, өрсөлдөгч, түнш зэрэг шууд нөлөөлөх олон хүчин зүйл байна. Судалгааг тодорхой, үр дүнтэй болгохын тулд эдгээрээс өрхийн эдийн засаг, сумын эдийн засаг, нийгмийн сэтгэлгээний хандлага гэсэн үндсэн 3 хүчин зүйлийг авч үзэж байна.

1. Өрхийн эдийн засгийн үзүүлэлт.
2. Сумын эдийн засгийн үзүүлэлт.
3. Нийгмийн сэтгэлгээний хандлага

**II.2.9 Өрхийн эдийн засгийн үзүүлэлт.** Малчин, малчин өрхийн хөрөнгийн эдийн засгийн тоон утга, хэмжих үзүүлэлтүүд. Малчин өрхийн сумын эдийн засагтай холбогдох, харилцан нөлөөлөх хүчин зүйлүүдийн утга.

**II.2.10 Сумын эдийн засгийн үзүүлэлт.** Малчны бизнесийг сум, төвлөрсөн зах зээлтэй холбоход нөлөөлөх гол хүчин зүйлийн тоон утга, хэмжих үзүүлэлтүүд юм. Сумын дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн бүтэц, хэмжээ зэрэг үзүүлэлтүүд.

Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн  
Газар, "МОН/01/Ю01/" төсөл

Сургалт, судалгаа, төсөл  
боловсруулах Цаг-Тоо ХХК

**II.2.11 Нийгмийн сэтгэлгээний хандлага** Малчдын зах зээлийн мэдлэг, чадвар, сэтгэлгээний төлөвшил, хорших хамтрах үйл ажиллагааны харилцаа, арга ажиллагааны хүчин зүйлүүд.

**Судлах зүйл, түүний шалгуур үзүүлэлтүүд**

Хүснэгт № 1

Үзүүлэлт	Өрхийн эдийн засаг Малчин өрхийн аж ахуйн тоон үзүүлэлтүүд	Сумын эдийн засаг Сумын мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтэц хэмжээ	Нийгмийн хандлага, сэтгэлгээ Малчдын санал, бодол
	1	2	3
<b>I. Малчин өрх, хөрөнгө</b>			
1. Хүн ам, боловсрол	Өрхийн ам бүл, боловсролын түвшин	Сумын хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн  Сумын хүн амын боловсрол, мэргэжлийн түвшин	<b>X</b>
2. Эргэлтийн хөрөнгө	Мөнгөн хөрөнгө, зээл, бараа бүтээгдэхүүн	Сумын банк санхүүгийн зах зээл	Эргэлтийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, сайжруулах тухай санал
3. Биет хөрөнгө	Малын бүтэц, тоо толгой, Өвөлжөө, хаваржаа, бэлчээр, худаг, машин техник	Сумын малын тоо, бүтэц Хөрөнгийн бүртгэл Газар зүйн байршил	Байгалиас хараат бус үл хөдлөх хөрөнгөтэй болох тухай санал
<b>II. Мал аж ахуйн бизнес</b>			
4. Бүтээгдхүүн	Малчин өрхийн үйлдвэрлэлийн хэмжээ	Сумын малын гаралтай түүхий эд үйлдвэрлэлийн нийт хэмжээ, үнэ	<b>X</b>
5. Хэрэглээ	Хүнс, өргөн хэрэглээний барааны хэмжээ, үнэ	Хүнс, өргөн хэрэглээний барааны сумын нийт хэмжээ, эргэлт	<b>X</b>
6. Борлуулалт, нийлүүлэлтийн суваг	Малын гаралтай түүхий эд борлуулалтын суваг, Өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийн суваг, эргэлт		Малын түүхий эдээ борлуулах болон Хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийн талаархи санал
7. Төсөв	Малчин өрхийн орлого зарлага, хуримтлал үүсгэх боломж /чинээлэг, дундаж, ядуу/	Сумын нийт төсвийн орлого, зарлагын хэмжээ	<b>X</b>
8. Мэдлэг, мэдээлэл	Зах зээлийн мэдлэг, мэдээлэл авах хэрэгсэл /радио, ТВ, хэвлэл/	Сумын хэмжээнд малчдад мэдээ, мэдээлэл хүргэх хүчин чадал	Зах зээлийн мэдлэг, ойлголт, Зах зээлийн тухай сургалтын хэрэгцээ
9. Хоршоо, хоршин ажиллах	Хоршооны гишүүнчлэл, үйлчилгээ, эдийн засгийн үр өгөөж	Хоршооны эдийн засгийн суурь	Хоршооны тухай санал

Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн  
Газар, "МОН/01/Ю01/" төсөл

Сургалт, судалгаа, төсөл  
боловсруулах Цаг-Тоо ХХК

## Судалгааны аргууд

Хүснэгт № 2

Үзүүлэлт	Өрхийн эдийн засаг <i>Малчин өрхийн аж ахуйн тоон үзүүлэлтүүд</i>	Сумын эдийн засаг <i>Сумын мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтэц хэмжээ</i>	Нийгмийн хандлага, сэтгэлгээ <i>Малчдын санал, бодол</i>
	1	2	3
<b>I. Малчин өрх, хөрөнгө</b>			
1. Хүн ам, боловсрол	Малчдаас санал асуулгаар	Улсын болон Сумын статистик мэдээ баримт	<b>X</b>
2. Эргэлтийн хөрөнгө	Малчдаас санал асуулгаар	Сумын санхүүгийн төсөв, Банкны мэдээлэл	Малчин, мал аж ахуйн бизнес эрхлэгч, хоршоологчидтой ярилцлага хийх
3. Биет хөрөнгө	Малчидаас санал асуулгаар, Сумын статистик мэдээ баримт	Улсын болон Сумын статистик мэдээ баримт	Малчин, мал аж ахуйн бизнес эрхлэгч, хоршоологчидтой ярилцлага хийх
<b>II. Мал аж ахуйн бизнес</b>			
4. Бүтээг-дэхүүн	Малчин өрхийн үйлдвэрлэлийн орлого, зардлын тооцоог аргачлал боловсруулан хийнэ	Сумын нийт үйлдвэрлэлийн орлого, зардлын тооцоог аргачлал боловсруулан хийнэ	<b>X</b>
5. Хэрэглээ		Барааны үнэ, ханшийн талаархи мэдээ баримт	<b>X</b>
6. Борлуулалт, нийлүүлэлтийн суваг	Малчдаас санал асуулга Сумын статистик мэдээ Малчидтай ярилцлага		Малчин, мал аж ахуйн бизнес эрхлэгч, хоршоологчидтой ярилцлага хийх
7. Малчин өрхийн төсөв	Малчидтай ярилцлага хийх, Малчин өрхийн төсвийн тооцоог аргачлал боловсруулан хийнэ	Сумын нийт бараа болон мөнгөн эргэлтийн төсөв тооцох аргачлал боловсруулан хийнэ Олон улсын болон МУ-ын Статистик мэдээ	<b>X</b>
8. Мэдлэг, мэдээлэл	Малчдаас санал асуулга	Сумын удирдлагаас санал асуулгаар	Малчин, мал аж ахуйн бизнес эрхлэгч, хоршоологчидтой ярилцлага хийх
9. Хоршоо, хоршин ажиллах	Малчдаас санал асуулга, ярилцлага	Нөхцөл байдлын оношлогооны аргачлал боловсруулан хийнэ.	

## **II.3 Түүврийн сонголт ба хэмжээ**

### **II.3.1 Судалгааны аргачлал буюу тандалтын судалгаа**

Малчин өрхийн амьдралын түвшин, эдийн засгийн сэтгэлгээний хандлагыг тодорхойлохын тулд малчидтай уулзаж, санал бодлыг авахдаа санал асуулгын аргаар авахаар төлөвлөсөн. Санал асуулгаар судалгааны зорилгод дэвшүүлж байгаа асуудлаа бүрэн гаргаж авахын тулд туршилт-тандалтын судалгааг явууллаа.

Тандалт-туршилтын судалгааны давуу тал нь:

- A. Санал асуулгын асуултууд нь судалгааны зорилго, аргачлалын шаардлагад нийцэж байгааг тодруулах, Судалгаанд дэвшүүлж байгаа зорилтууд (малчны бүтээмж, хөрөнгө, зээл, хоршоо)-ыг Санал асуулгаар бүрэн тодорхойлж болох эсэх, нэмэлт өөр аргачлал шаардагдахыг тодорхойлох,
- B. Судалгаанд оролцогч малчдын боловсролын болон зах зээлийн сэтгэлгээний түвшингээс хамаарч Санал асуулгын хуудас бүрэн зөв бөглөгдөх магадлал хэр зэрэг байгааг тодруулах

Санал асуулгаар авсан мэдээлэлдээ боловсруулалт хийхэд зорилгод нийцсэн мэдээлэл үр дүнг өгч чадахыг шалгах зэрэг давуу талуудтай болно.

### **II.3.2 Судалгааны түүврийн хэмжээ ба сонголт**

Судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо дараах шалгуурыг авч үзсэн болно. Үүнд:

- A. Монгол улсын нийт 329 сумын дунджаар нэг суманд 380-400 малчин өрх байдаг. Мал аж ахуй давамгайлсан суманд дунджаар 400-600 малчин өрх, газар тариалан эрхэлдэг суманд 30-100 малчин өрх байна.
- B. Судалгаанд малчин өрхийн амьдралын түвшинг тооцон үзсэн. Үүнд ядуувтар, дундаж, чинээлэг гэж ангилан үзэхдээ улсын нэгдсэн жишиг хэмжээ, сумын удирдах ажилтнуудын ангилал, судлаачдын аргачлалыг тооцон үзэв.. Чинээлэг түвшингээс 20%, дундаж түвшингээс 40%, ядуувтар түвшингээс 40% тус тус байхаар төлөвлөж санамсаргүй түүврийн аргаар судалгааг авав.
- C. Санал асуулгыг малчин өрхөөс төлөөлүүлэн авч байна. Нэг малчин өрхийн малын тоо, амьдралын түвшин, ам бүлийн тоог нэг гишүүн төлөөлөн хэлэх боломжтой юм.

### **Судалгааны байрлал**

#### **II.3.3 Судалгааг авах орон нутгыг дараахь байдлаар сонгосон болно.**

1. Монгол улсын эдийн засгийн бүс бүрээс төлөөллүүлэх зорилт тавьсан болно. Үүнд:
  - A. Баруун бүсээс – Завхан аймаг,
  - B. Хангайн бүсээс - Өвөрхангай,

- 
- C. Зүүн бүсээс – Хэнтий, Дорнод,
  - D. Говийн бүсээс - Өмнөговь,
  - E. Төвийн буюу хойд бүсээс Сэлэнгэ зэрэг нийт 6 аймгийг сонгосон болно.
2. Сонгосон аймаг тус бүрт мөн дараах шалгуур сонголтыг хийсэн. Үүнд:
- A. Аймаг, хот буюу төвлөрсөн зах зээлтэй ойр сум
  - B. Аймаг, хот буюу төвлөрсөн зах зээлтэй дундаж сум
  - C. Аймаг, хот буюу төвлөрсөн зах зээлээс алслагдсан сум
  - D. Эдгээр сумууд нь аймгаас мөн дөрвөн зүгт байрлах
  - E. Хангай, говь, тал хээр гэсэн байгалийн онцлог буюу малын бүтэц зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулан үзэж сонгосон болно.

#### II.3.4 Тайлбар

- a. Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, МУ-ын Үндэсний статистикийн газар, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Өмнөговь аймгийн тооллогын дүнг ашиглав.
- b. Тус эх сурвалжуудад “Хөдөөгийн хүн ам” гэсэн хувиар үзүүлсэн (Хүснэгтийн 6-р багана) баримтаас Хөдөөгийн хүн амын тоог (7-р багана) гаргав.
- c. Хөдөөгийн өрхийн ам бүлийн дундаж тооноос үндэслэн Малчин өрхийн тоог гаргав.
- d. Судалгааг тухайн сумын Малчин нийт өрхийн 8-20% (дундаж 10%) буюу 23-103 малчин өрхийг (дундаж 46 өрх) түүвэрлэхээр хэмжээг төлөвлөж байна.

## Бүлэг III. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### III.1 ӨНӨӨГИЙН МАЛЧДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

#### III.1.1 Малчин өрхийн ам бүл, боловсрол

III.1.1.1 Улсын дунджаар<sup>1</sup> өрхийн дундаж хүн ам 2.2 байхад хөдөөгийн малчин өрхийн дундаж ам бүлийн тоо 4.8 байна. Нийт 1000 малчдаас авсан дүнгээр 23% нь 1-3 ам бүлтэй, 58.6% нь 4-6 ам бүлтэй, 18.1% нь 7-оос дээш ам бүлтэй байна. Хот, суурин газартай харьцуулахад малчин өрхийн ам бүлийн тоо 2.6-аар их байна.

III.1.1.2 Малчдын 6.3% нь сургуульд сураагүй, 27.3% нь 4-р анги төгссөн, 34.4% нь 8-р анги, 20.8% нь 10-р анги, 11.3% нь ТМС, техникум болон дээд сургууль төгссөн байна. Өнөөгийн малчдын боловсролын түвшин харьцангуй доогуур байгаа нь мал аж ахуйгаа эрчимжүүлэх, зах зээлийн харилцаанд бүтээмжтэй ажиллах, байгалийн хараат бус байдлаас гарах талаар бодох, зорилго төлөвлөгөөтэй ажиллахад мэдлэг, чадвар дутагдаж байна.

**Хүснэгт 3** Малчдын боловсролын түвшин болон хүйсийн харьцаа


Боловсролын түвшин	Хүйс				Нийт
	Эрэгтэй	Хувь	Эмэгтэй	Хувь	
Сураагүй	40	6.1%	23	6.7%	63
4-р анги төгссөн	182	27.6%	91	26.6%	273
8-р анги төгссөн	231	35.1%	113	33.0%	344
10-р анги төгссөн	123	18.7%	85	24.9%	208
ТМС, Техникум	46	7.0%	18	5.3%	64
Дээд	37	5.6%	12	3.5%	49
Нийт	659	100%	342	100%	1000

III.1.1.3 Сургуульд сураагүй эрэгтэй 6.1%, эмэгтэй 6.7%; 4-р анги төгссөн эрэгтэй 27.6%, эмэгтэй 26.6%; 8-р анги төгссөн эрэгтэй 35.1%, эмэгтэй 33.0%; 10-р анги төгссөн эрэгтэй 18.7%, эмэгтэй 24.9%; ТМС, техникум төгссөн эрэгтэй 7%, эмэгтэй 5.3%; дээд боловсролтой эрэгтэй 5.6%, эмэгтэй 3.5% тус тус байна. Хүснэгт № 3

<sup>1</sup> 2001 оны МУ-ын Статистикийн мэдээ

**III.1.1.4** Малчдын боловсрол эзэмшсэн байдалд үнэлгээ харьцуулалт хийж үзвэл 10-р анги төгссөн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 6%-иар илүү, харин сургуульд сураагүй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.6%-иар бага, ТМС болон түүнээс дээш боловсролтой эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3.8%-иар бага байна.

**III.1.1.5** Малчдын боловсрол эзэмшсэн байдлыг насаар нь харьцуулан үзвэл дундаж насны /31-50/ малчид 4, 8, 10-р анги төгссөн нь ахимаг /51-ээс дээш насныхан/ болон залуучуудаас харьцангуй илүү байна. Залуучуудын хувьд /30 хүртэл насныхан/ өмнөх үесээ боловсролоор доогуур байна. Энэ нь 1990 оны эхээр малчид хүүхдүүдээ сургуулиас гаргаж, завсардуулж байсантай холбоотой юм.



**Хүснэгт 4** Малчдын боловсрол, насны харьцаа

Боловсрол	Насны бүлэглэл						Нийт
	20 хүртэл	21-30	31-40	41-50	51-60	61-дээш	
Бичиг үсэг мэдэхгүй	3	12	13	8	16	11	63
4-р анги төгссөн	10	22	76	62	68	35	273
8-р анги төгссөн	9	63	126	102	31	13	344
10-р анги төгссөн	11	47	53	64	20	12	207
ТМС, Техникум		11	18	23	9	3	64
Дээд	-	11	13	14	6	5	49
<b>Нийт</b>	33	166	299	273	150	79	1000

### III.1.2 Малчдын мэдээллийн суваг

**III.1.2.1** Малчдын 51.5% нь радиогоос, 15.4% зурагтаас, 3.0% нь сонин хэвлэлээс, 2.3% нь баг сумын захиргааны мэдээллээс, 17.0% нь малчдаас зах зээлийн мэдээлэл авч байна. Малчдын мэдээлэл авдаг суваг харьцангуй олон болсон байна. ТВ-ээс мэдээлэл авдаг 15.4% гэж хариулсан нь нэг өвөлжөө, хотонд байгаа айлууд нэг ТВ-тэй, түүнийг үздэгээ хариулсантай холбоотой юм.



III.1.2.2 Малчдын дийлэнх нь мэдээллийг зурагт радиогоос гэж хариулсан нь мэдээллийг цаг тухайд авч чаддаг болохыг харуулж байна. Үүний зэрэгцээ 2.3% нь баг, сумын захиргааны мэдээллээс гэж хариулсан нь сумын ЗДТГ, ИТХ-аас иргэддээ мэдээлэл түгээх талаар санаачилга гаргахгүй байгааг харуулж байна.

\* \* \*

## III.2 МАЛЧИН ӨРХИЙН ХӨРӨНГИЙН БҮТЭЦД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ


### III.2.1 Малчин өрхийн малын бүтэц

III.2.1.1 Малчин өрхийн хөрөнгийг мал сүрэг, техник хэрэгсэл, хөдөлгөөнгүй хөрөнгө гэсэн 3 ангилалаар авч үзэв.

III.2.1.2 Малчин өрхийн мал сүргийг таван төрлөөр (тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа) авч үзэхийн зэрэгцээ малын тооны бүлэглэлийг Монгол Улсын Үндэсний Статистикийн Газрын ангилалыг баримтлав.

#### А. Үхэр


III.2.1.3 Үхэртэй 648 малчин өрхийн 59.4% нь 10 хүртэл, 24.7% нь 11-30, 9% нь 31-50, 2.9% нь 51-100, 3.1% нь 101-200, 0.9% нь 201-ээс дээш үхэртэй байна. 39 респондент 51-200 үхэртэй гэж хариулсан нь өрхийн мал сүрэгт үхэр бага хувь эзэлж байна.



III.2.1.4 Бод малын тоог ам бүлийн тоотой харьцуулж үзэхэд 51-ээс дээш толгой бод малтай өрхийн ам бүлийн тоо гол төлөв 4-ээс дээш байна. Өөрөөр хэлбэл мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөр оролцоо их, нөгөө талдаа ажлын байр бий болгож байдгийг харуулж байна. Мөн үхэр сүрэг сүүлийн 2-3 жилд их хорогдсонтой холбоотой юм.

#### В. Адуу


III.2.1.5 Адуутай 700 малчин өрхийн 54.0% нь 10 хүртэл, 30.1% нь 11-30, 9.1% нь 31-50, 4.6% нь 51-100, 1.6% нь 101-200, 0.6% нь 201-ээс дээш адуутай байна.



**III.2.1.6** Адууг хүнсэнд ашиглахаас илүүгээр уналгад ашиглаж байгаа бөгөөд респондентын 15.9% нь 31-ээс дээш адуутай байна.

### **C. Тэмээ**

**III.2.1.7** Тэмээтэй 420 малчин өрхийн 67.2% нь 10 хүртэл, 21.9% нь 11-30, 5.7% нь 31-50, 2.4% нь 51-100, 2.4% нь 101-200, 0.5% нь 201-ээс дээш тэмээтэй байна.




**III.2.1.8** Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 42% нь тэмээтэй байна. Сүүлийн 1-2 жилүүдэд тэмээн тоо цөөрсөн, мөн бүтээгдэхүүнийг нь зах зээлд борлуулах нь багатай холбоотой юм.

### **D. Хонь**


**III.2.1.9** Хоньтой 905 малчин өрхийн 16.6% нь 10 хүртэл, 15.1% нь 11-30, 25.5% нь 31-50, 23.6% нь 51-100, 11.6% нь 101-200, 5.7% нь 201-500, 1.1% нь 501-999, 0.7% нь 1000-аас дээш хоньтой байна.

**III.2.1.10** 201-500 хоньтой 52 малчин, 501-999 хоньтой 10 малчин, 1000-дээш хоньтой 6 малчин судалгаанд хамрагдсан байна.



## **Ф. Ямаа**

**III.2.1.11** Ямаатай 936 малчин өрхийн 11.2% нь 10 хүртэл, 20.0% нь 11-30, 25.0% нь 31-50, 17.9% нь 51-100, 15.3% нь 101-200, 9.7% нь 201-500, 0.7% нь 501-999, 0.1% нь 1000-аас дээш ямаатай байна.



## **Малчин өрхийн малын бүтэц**


**III.2.1.12** Таван төрлийн малын бүтцийг зэрэгцүүлэн авч үзвэл дараахь байдалтай байна. Энэхүү малын төрөл, тооны бүлэглэл нь МУ-ын 2002 оны малын тооны бүлэглэлтэй ерөнхий бүтцээр ижил бөгөөд өрхийн тооны харьцаагаар бага байгаа нь улсын хэмжээнд малын тоо буурч байгаатай холбоотой юм. Малын төрөлд үхэр, ямаа давамгайлах, сүүний чиглэлийн үрхийн тоо ихэсч байгаа нь малчид бүтээмж гарц өндөртэй мал сүргийг маллах болж байгаатай холбоотой юм.

**Хүснэгт 5 Малчин өрхийн малын бүтэц**

Бүлэглэл	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Дундаж
1. 10 хүртэл	283	378	385	150	105	260.2
2. 11-30	92	211	160	137	187	157.4
3. 31-50	24	64	58	231	234	122.2
4. 51-100	10	32	19	214	168	88.6
5. 101-200	10	11	20	105	143	57.8
6. 201-500	2	4	6	52	91	31
7. 501-999	-	-	-	10	7	8.5
8. 1000-аас дээш	-	-	-	6	1	3.5

### III.2.2 Малчин өрхийн техник хэрэгсэл

III.2.2.1 Малчдын техник хэрэгслийг 5 бүлэгт ангилж судалгаа үнэлгээг хийсэн бөгөөд 1000 малчдын 297 нь мотоциклтой, 288 нь машин трактортой байна. Малчид харьцангуй техник хэрэгсэл багатай, нөгөөтэйгүүр судалгаанд хамрагдсан малчид нь амьжиргааны хувьд дундаж, ядуувтар түвшний өрхүүд байсантай холбоотой болно.



III.2.2.2 Малчдын 0,08% нь жижиг үйлдвэрлэл явуулах тоног төхөөрөмжтэй гэж хариулсан нь малчид өнөөдрийн байдлаар мал маллахын зэрэгцээ үйлдвэрлэл эрхлэх санал санаачлага гаргахгүй, зөвхөн өдрөө аргацаасан байдлаар амьдарч байгааг харуулж байна.

III.2.2.3 Малын гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх бага оврын үйлдвэрлэлийн багаж техник байхгүй байгаа нь


1. Нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэлийн чанартай үйл ажиллагаа эрхэлдэггүй,
2. Малын /хөрөнгийнхөө/ үр ашгийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

III.2.2.4 Малчдын 3% нь цахилгааны эх үүсвэртэй гэж хариулсан, 34% нь огт хариулт өгөөгүй нь малгүй мөн ямар нэг техник хэрэгсэлгүй ядуу малчид олшрох хандлагатай байгааг харуулж байна.

### III.2.3 Малчин өрхийн хөдөлгөөнгүй хөрөнгө

III.2.3.1 Малчдын 51% хувь өвөлжөөний хашаа хороотой, 11% нь хаваржаатай байна. Учир нь малчид нэг өвөлжөөнд 2-3 айлаараа өвөлжих буюу өвөлжөөгөө хамтран ашигладаг. Хот айлд өрх тусгаарласан хүү нь эцэг, эхтэйгээ айл буусан, эсвэл ах дүүгээрээ хотлон амьдрах хэлбэрээр зохион байгуулагджээ.

III.2.3.2 Малчдын ногооны газар нь малчны хэрэглээний хүнсний ногоо тариалах зориулалттай, албан бус эзэмшлийн газар юм. Малчид голдуу гар аргаар ухсан 5-10 метрийн гүнтэй, гар ажиллагаатай худгаар ундны усны хэрэгцээгээ хангаж байна. Худагтай гэж 1%, ногооны газартай гэж 3% нь хариулсан нь харьцангуй доогуур үзүүлэлт юм. Дээрх үл хөдлөх хөрөнгийн төрлүүдээс аль нь ч байхгүй гэж 17% нь хариулсан нь малаас өөр үндсэн хөрөнгөгүй малчин нэлээд байгааг харуулж байна.



### III.3 МАЛЧДЫН ХӨРӨНГИЙН ЭРГЭЛТЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

#### III.3.1 Нийлүүлэлт борлуулалтын суваг

III.3.1.1 Малчин нь нэгэн зэрэг үйлдвэрлэгч, хэрэглэгч болж байдаг. Иймээс өөрийн өвөрмөц шинж чанартай борлуулалт, нийлүүлэлтийн сувагтай.

III.3.1.2 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн буюу малын гаралтай түүхий эдээ /МГТЭ/ зах зээлд борлуулж буй борлуулалтын суваг болон малчин өрхийн хүнс, өргөн хэрэглээний бараа/ХӨХБ/-гаа зах зээлээс бэлтгэн нийлүүлж байгаа нийлүүлэлтийн суваг хоёр нь тухайн сумын дэд бүтэц, зах зээлийн орчин бүрэлдэж байгаагаас шалтгаалан сум бүрд харилцан адилгүй байна.

III.3.1.3 *Малынхаа түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрхэн борлуулдаг вэ?* гэсэн асуултанд Зээлээр авсан барааны төлбөртөө өгдөг 21.0%, Сумын төвийн худалдааны компанид бэлэн мөнгөөр өгдөг 22.4%, Хот аймгаас наймаачид ирээд авдаг 33.8%, Өөрсдөө 31.7%, Нийлээд борлуулдаг 16.8% байна.


III.3.1.4 Түүхий эдээ хэд хэдээрээ нийлээд борлуулдаг гэж 16.8% буюу 168 малчин хариулсан. Энэ нь нэг хот айлд амьдардаг өрхүүд нийлээд түүхий эдээ борлуулж байгаа утга бөгөөд хэд хэдэн хот айлаар буюу баг, сумаараа нийлж борлуулж байгаа арга ажиллагаа байхгүй байна.

III.3.1.5 Дангаараа өөрсдөө төвлөрсөн зах зээлд борлуулдаг, төвөөс ченжүүд ирээд авдаг хэлбэрүүд байгаа нь малчиддаа ашигтай байгаа ч сум орон нутагт алдагдалтай хувилбар юм. Учир нь түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалтын орлогын мөнгөн урсгал гадагшаа чиглэгдэж байна.

III.3.1.6 Цөөн малтай малчид гол төлөв зээлээр авсан хүнс, өргөн хэрэглээнийхээ барааны төлбөрт түүхий эдээ өгдөг нь өөр орлогогүй малчдын хувьд тогтсон нэг борлуулалтын сувгийн хэлбэр болжээ.


III.3.1.7 *МГТЭ, бүтээгдэхүүнээ борлуулах талаар малчдын санаачилга бага, харин түүхий эдийг наймаачид очиж авч байгааг тохиромжтой гэж үзэх хандлагатай байна.*

*Малчид малынхаа түүхий эдийг борлуулдаг тогтсон нэг борлуулалтын суваггүй, зөвхөн тухайн нөхцөлд аль ашигтайг нь харж түүхий эдээ борлуулж байна.*



Малын гаралтай түүхий эд борлуулж байгааг малын төрөл, тоотой харьцуулахад төдийлөн их хамааралгүй харин тухайн сумын зам тээвэр, зах зээлийн төлөвшилөөс хамаарч байна.

**III.3.1.8 Өрхийн өргөн хэрэглээний бараагаа хаанаас хэрхэн худалдаж авдаг вэ?** гэсэн асуултанд 34.3% нь сумын компаниас зээлээр, 30.2% хот аймгийн



ченжүүдээс, 45.6% нь сумын компани, хоршооноос авдаг, 11.7% нь хот аймгийн



ченжүүдээс бараа солилцоогоор авдаг, 23.3% нь өөрсдөө худалдаж авдаг гэж хариулсан байна.

**III.3.1.9** Малчдын дунд түүхий эд малын гаралтай бүтээгдэхүүнээ зээлээр авсан барааны төлбөрт сумын төвийн худалдааны компаниудад өгдөг нь илүү байна. Энэ нь бэлэн мөнгөний төлбөрийн чадваргүй тул хүнсний болон ахуйн бараагаа урьдчилж зээлээр авч, малын гаралтай түүхий эдээ бэлтгэсний дараа сумын компани хоршооноос худалдан авсан барааныхаа төлбөрт өгдөг бараа солилцооны арилжаа хийгдэж байна. Нөгөө талдаа сумын компани нь малчдын хэрэгцээг хангах барааг боломжийн үнээр өгч олон жил бие биеэ таньсан итгэлцэл дээр тулгуурлаж ажилладагтай холбоотой юм.

**III.3.1.10** МГТЭ-ийн борлуулалт, ХӨХБ-ний нийлүүлэлтийн сувгийг харьцуулж үнэлгээг хийвэл:

1. МГТЭ-ийг ченжүүд ирээд авдаг 38.6%, ХӨХБ-аа ченжүүдээс авдаг 27.5% буюу огтолзол нь 24 байгаа нь бусдаас харьцангуй их байна. Энэ нь сум орон нутагт харьяалалгүй явуулын хүмүүс МГТЭ-ийг ХӨХБ-ний солилцоогоор хийдэг ганзагын наймаа эзэлсэн буюу сумын зах зээлийн нийлүүлэлт-борлуулалтын сувгийн удирдлага зохицуулалт байхгүйг харуулж байна.

**Хүснэгт 6** Борлуулалт, Нийлүүлэлтийн сувгийг харьцуулалт

Үзүүлэлт		Хүнс, Өргөн Хэрэглээний Барааны нийлүүлэлт					
		Сумын компани хоршооноос бэлэн мөнгөөр авдаг	Сумын компани хоршооноос зээлээр авдаг	Хот, аймаг, сумын ченжүүдээс бэлэн мөнгөөр авдаг	Хот, аймаг, сумын төвийн ченжүүдээс бараа солилцоогоор авдаг	Хот, аймаг, хилийн боомтоос өөрсдөө худалдаж авдаг	Эзлэх хувь
Малын Гаралтай Түүхий Эд Бүтээгдэхүүний борлуулалт	Нийлээд аймгийн төв, хот, боомтонд аваачиж борлуулдаг	2	1	2	3	3	5.8%
	Дангаараа аймгийн төв, хот, боомтонд аваачиж борлуулдаг	7	12	8	9	13	25.9%
	Хот, аймаг сумын төвөөс ченжүүд ирээд авдаг	13	16	13	24	7	38.6%
	Сумын төвийн худалдааны компани хоршоонд зээлийн төлбөрт өгдөг	6	14	3	11	3	19.6%
	Сумын төвийн худалдааны компани хоршоонд бэлэн мөнгөөр өгдөг	6	4	3	5	1	10.1%
		18.0%	24.9%	15.3%	27.5%	14.3%	

2. Дангаараа төвлөрсөн зах зээлд нийлүүлж /25.9%/, тэндээсээ ХӨХБ-аа худалдаж /13/ авахын зэрэгцээ сумын компани хоршооноос зээлээр авдаг /12/ байна. Энэ нь хэдийгээр борлуулалтыг өөрсдөө хийсэн ч бэлэн мөнгөний хэрэгцээгээ хангаж чаддаггүй, мөн зээлээр авах нь ашигтай буюу бэлэнчлэх байдлаа хадгалах хандлагатайг харуулж байна.
3. ХӨХБ-аа ихэвчлэн сумын компани, хоршооноос зээлээр авдаг /24.9%/ нь нэг талдаа сумын компани, хоршоо малчиддаа илүү ойр үйлчилдгийг харуулж байна.

**III.3.1.11 Явуулын худалдаачид нь өөрсдийн ашгаа л бодохоос малчдын эрэлт хэрэгцээг хангах чанартай бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж чадахгүй, малчид нэгдэж нийлээд үнэ хүргэж болох байтал орон нутгийн хөгжилд нь нэмэр болохгүй явуулын худалдаачдыг дэмжсээр байна.**

**III.3.1.12 ХӨХБ-аа сумынхаа компани, хоршооноос зээлээр авдаг нь эргээд тэр аж ахуйн нэгжийнхээ мөнгөн эргэлтэнд нөлөөлж сумынхаа эдийн засгийг доройтуулахад түлхэц болж байна.**

### III.3.2 Малчин өрхийн орлого, зарлага

#### Малчин өрхийн орлого

III.3.2.1 Малчин өрхийн орлогыг малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарцын МУ-ын стандарт хэмжээг үндэслэн тухайн малчин өрхийн малын тооноос хамааруулан тооцоолов. Тооцоонд малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнийг Өвөрхангай, Архангай, Хөвсгөл аймгуудын зах зээлийн 2003 оны 3-р сарын дундаж үнээр авч тооцоог хийв.

#### Хүснэгт № 7.а Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарцын хэмжээ, үнэ

/2003 оны 3 сарын үнээр/

Малын төрөл/ Гарц	1. Ноос, Ноолуур (кг)		2. Хөөвөр, Хялгас (кг)		3. Арьс, шир (ширхэг)		4. Мах (кг)	
	Гарц	Үнэ	Гарц	Үнэ	Гарц	Үнэ	Гарц	Үнэ
1. Тэмээ	4.5	1700						
2. Адуу			0.26	150	0.09	6000	12.76	425
3. Үхэр			0.27	150	0.14	8000	21.7	624
4. Хонь	1.3	150			0.2	2500	4.8	822
5. Ямаа	0.24	18000	0.01	150	0.2	5000	3.04	506
Бэлтгэлийн хугацаа	5, 6		5, 6		11, 12		11, 12	

#### Хүснэгт № 7.б

Малын төрөл / Гарц	5. Айраг, сүү (литр)		6. Өлөн гэдэс /гор/	
	Гарц	Үнэ	Гарц	Үнэ
1. Тэмээ	0.0			
2. Адуу	23.8	300		
3. Үхэр	102.2	330		
4. Хонь	3.7	330	0.1	200
5. Ямаа	6.9	330	0.1	200
Бэлтгэлийн хугацаа	6, 7, 8, 9		11, 12	

Тайлбал: Гарцын хэмжээ нь 1. Ноос, ноолуур, 2. Хөөвөр, хялгас зэрэг нь 1 толгой, 3. Арьс шир, 4. Мах, 5. Айраг, 6. Өлөн гэдэс зэрэг нь 5 толгой тутмаас авах хэмжээ болно.

III.3.2.2 Жишээлбэл, Өвөрхангай аймаг, Есөн зүйл сумын малчин Сумъяагийн ам бүл 5 бөгөөд 20 адуу, 15 үхэр, 75 хонь, 150 ямаатай, өөрсдийн гараар бэлтгэсэн худагтай. Энэ өрхийн орлогыг тооцон үзвэл.

#### Хүснэгт № 8.а Малчин өрхийн орлогын тооцоо /жишээ/

Малын		1. Ноос, Ноолуур (кг)		2. Хөөвөр, Хялгас (кг)		3. Арьс, шир (ширхэг)		4. Мах (кг)	
Төрөл	Тоо	Гарц	Үнэ	Гарц	Үнэ	Гарц	Үнэ	Гарц	Үнэ
Тэмээ	0	-	-	-	-	-	-	-	-
Адуу	20	-	-	5.2	780.0	1.8	10,800.0	255.2	108,460.0
Үхэр	15	-	-	4.1	607.5	2.1	16,800.0	325.5	203,112.0
Хонь	75	97.5	14,625.0	-	-	15.0	37,500.0	360.0	295,920.0
Ямаа	150	36.0	648,000.0	1.5	225.0	30.0	150,000.0	456.0	230,736.0
<b>Дүн</b>	<b>260</b>		<b>662,625.0</b>		<b>225.0</b>		<b>215,100.0</b>		<b>838,228.0</b>
Бүтээг-ний	Орл-д эзлэх хувь		23.4%		0.01%		7.6%		29.6%

Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн  
Газар, "МОН/01/Ю01/" төсөл

Сургалт, судалгаа, төсөл  
боловсруулах Цаг-Тоо ХХК

**Хүснэгт № 8.6**

Малын		5. Айраг, сүү (литр)		6. Өлөн гэдэс /гог/		Нийт орлого /төгрөгөөр/	Мал.төрлөөр Орлогод эзлэх хувь
Төрөл	Тоо	Гарц	Үнэ	Тоо	Үнэ		
Тэмээ	0	-	-	-	-	-	0.0%
Адуу	20	476.0	142,800.0	-	-	262,840	9.3%
Үхэр	15	1,533.0	505,890.0	-	-	726,410	25.7%
Хонь	75	277.5	91,575.0	7.5	1,500	439,620	15.5%
Ямаа	150	1,035.0	341,550.0	15.0	3,000.0	1,400,511	49.5%
<b>Дүн</b>	<b>260</b>		<b>1,081,815.0</b>		<b>30,000.0</b>	<b>2,827,993</b>	
Бүтээг-ний Орл-д эзлэх хувь			38.3%		1.1%	100%	100.0%

III.3.2.3 Малчин Сумъяагийн жилдээ 2 сая 828 төгрөгийн борлуулалтын орлоготой, сардаа дунджаар 235 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой байна. Нийт орлогод бүтээгдэхүүний эзлэх хувиар авч үзвэл ноос, ноолуур 23,4%, мах 29,6%, айраг сүү 38.3%, арьс шир 7.6% тус тус байна.

III.3.2.4 Нийт орлогод ямаа 49.5%, үхэр 25.7%, хонь 15.5%-ийг эзэлж адууний эзлэх хувь бага байна. Ноолуурын үнэ бусад түүхий эдээс илүү үнэтэй, үхэр илүү таваарлаг шинжтэйг малчин Сумъяа тодорхойлж сүргийн бүтцээ өөрчилж ашиг өндөртэй байхаар зохион байгуулсан байна.

III.3.2.5 Өрхийн орлого талаасаа сүргийн бүтцээ өөрчлөхийн зэрэгцээ бэлчээр ашиглалтыг анхаарч байгаа нь ажиглалтаар харагдаж байлаа.

Малчин өрхийн зарлага

III.3.2.6 Малчин өрхийн зарлагыг тооцоолохдоо \*Монгол улсын Статистикийн эмхтгэлийн (2002 он, 17.7) "Жишсэн нэг хүнд сард оногдох хүнсний зарим бүтээгдэхүүний улсын дундаж хэрэглээний хэмжээ"-г өрхийн ам бүлийн тоотой харгалзуулан тооцоолов. Үүнд \*\*Нэгж үнийг 2003 оны 3-р сарын үнээр, \*\*\* Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлсийн үнийг нэмүү өртөг тооцоогүй үнээр авав.

III.3.2.7 Жишээлбэл, 5 ам бүлтэй малчин өрхийн жилийн хэрэгцээ үнийн дүнгээр 1,617,441 төгрөг (үндсэн зардал 1,409,040 төгрөг үүн дээр баяр, наадмын зардал 208400 төгрөг), сарын дундаж 135 мянган төгрөг байна.

### Хүснэгт 9 Малчин өрхийн зарлагын тооцоо / 5 ам бүлтэй өрх/

Зарлагын төрөл	Хэмжих нэгж	Нэг хүний дундаж хэрэглээ*	Нэгж үнэ** /төгрөг/	Өрхийн сарын зарлага		Өрхийн жилийн үндсэн зарлага		
				Хэрэглээ	Үнэ	Хэрэглээ	Үнэ	
<b>Нийт зардал</b>					<b>117,420</b>		<b>1,409,040</b>	
<b>I. Мөнгөн зарлага</b>					<b>73,433</b>		<b>881,190</b>	
<b>1</b>	<i>Хүнсний зүйлийн зарлага</i>				31,812.5		381,750.0	
1	Гурил, гурилан бүтээгдэхүүн	кг	9.9	450.0	49.5	22,275.0	594.0	267,300.0
2	Будаа	кг	1.2	650.0	6.0	3,900.0	72.0	46,800.0
3	Чихэр, сахарын зүйл	кг	0.8	650.0	4.0	2,600.0	48.0	31,200.0
4	Төмс	кг	0.7	350.0	3.5	1,225.0	42.0	14,700.0
5	Хүнсний ногоо	кг	0.4	350.0	1.8	612.5	21.0	7,350.0
6	Жимс, жимсгэнэ	кг	0.2	800.0	0.8	600.0	9.0	7,200.0
7	Ургамлын тос	кг	0.1	1,200.0	0.5	600.0	6.0	7,200.0
<b>2</b>	<i>Хүнсний бус барааны зарлага</i>				26,444.0	-	317,328.0	
1	Бөс бараа				2,104.0		25,248.0	
2	Бэлэн хувцас				6,793.0		81,516.0	
3	Гутал, ботинк				6,662.0		79,944.0	
4	Соёлын бараа				771.0		9,252.0	
5	Гэр, гэр ахуйн бараа				3,038.0		36,456.0	
6	Эм, эрүүл ахуй, гоо сайхан				1,187.0		14,244.0	
7	Түлшний зүйл				1,712.0		20,544.0	
8	Гэр ахуйн засварын материал				206.0		2,472.0	
9	Бусад бараа				3,971.0		47,652.0	
<b>3</b>	<i>Үйлчилгээний зарлага</i>				15,176.0		182,112.0	
1	Тээвэр, холбоо				4,710		56,520.0	
2	Ахуйн үйлчилгээ				111		1,332.0	
3	Боловсрол				4,856		58,272.0	
4	Эрүүл мэндийн төлбөр				215		2,580.0	
5	Татвар хураамж				1,070		12,840.0	
6	Нүүдэл				4,214		50,568.0	
<b>II</b>	<b>Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлс</b>						<b>43,988</b>	
1	Мах, махан бүтээгдэхүүн	кг	10.6	600.0	53.0	31,800.0	636.0	381,600.0
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	кг	15.8	150.0	78.8	11,812.5	945.0	141,750.0
3	Өөхөн тос	кг	0.1	750.0	0.5	375.0	6.0	4,500.0

### **III.3.3 Амьжиргааны түвшингийн ангилал**

#### **Малчин өрхийн амьжиргааны түвшин**

III.3.3.1 Малчин өрхийг амьжиргааны түвшингээр нь чинээлэг, дундаж, ядуувтар гэж ангилж тус бүрийнх нь орлого, зарлагыг тооцоолов.

III.3.3.2 Малчин өрхийг 51-ээс олон бод малтайг чинээлэг, 11-50 хүртэл бод малтайг дундаж, 10 хүртэл бод малтайг ядуувтар гэж үзлээ. Нийт 1000 малчин өрхийн 51-ээс олон тэмээтэй 22 өрх, 51-ээс олон адуутай 47 өрх, 51-ээс олон үхэртэй 45 өрх "чинээлэг" гэсэн ангилалд багтаж байна. 11-50 бодтой буюу тэмээтэй 116, адуутэй 275, үхэртэй 218 малчин өрх "дундаж" гэсэн ангилалд, 10 хүртэл бодтой буюу тэмээтэй 282, адуутай 378, үхэртэй 385 малчин өрхийг "ядуувтар" гэсэн ангилалд багтааж үнэлгээг хийлээ.

III.3.3.3 201-ээс олон хоньтой 68, ямаатай 99 малчин өрхийг "чинээлэг", 31-200 хүртэлх хоньтой 550, ямаатай 545 өрхийг "дундаж", 30 хүртэл хоньтой 287, ямаатай 292 малчин өрхийг "ядуувтар" гэсэн ангилалд авч үзлээ.

III.3.3.4 Судалгаа үнэлгээнд хамрагдсан нийт 1000 малчин өрхийн 7.8% нь чинээлэг, 47.2% нь дундаж, 45.0% нь ядуувтар гэсэн ангилалд багтаж байна.

III.3.3.5 Малчин өрхийн амьжиргааны түвшинг малын тоогоор нь авч үзэхэд анхаарах зүйлс:

1. Малчин өрхийн үйлдвэрлэлийн гол хэрэгсэл, амьжиргааны үндэс, хөрөнгө орлогын эх сурвалж нь мал тул малын тооноос тухайн малчны чинээлэг, дундаж, ядуувтар байх нь шууд хамааралтай юм.
2. Байгалийн бүсчлэл /говь, хангай, хээр/, эдийн засгийн бүсчлэл /дэд бүтэц, зам тээвэр, зах зээлийн төлөвшил г.м/ зэргээс шалтгаалан аймаг, сум, баг бүрд байгаа малын төрөл, үүлдэр угсаа, сүргийн бүтэц, тоо харилцан адилгүй байна.
3. Малчин өрхийн ам бүл, ажиллах хүчнээс шалтгаалж малын тоо, амьжиргааны түвшин нь өөр байна.
4. Малчны аж ахуйгаа эрхлэх ухаан, идэвхи чармайлт хөдөлмөрч чанар зэргээс шалтгаалан адил тооны малтай өрх амьжиргааны өөр өөр түвшинд байна.

III.3.3.6 Эдгээр хүчин зүйлийг харгалзан бүс нутаг, сум, баг бүрээр малчны амьжиргааны түвшин, малын тооны зохистой хэмжээг өөр өөр байхыг анхаарч, судалгаа үнэлгээний үр дүнг тодорхой болгохын тулд малын тооноос шалтгаалан малчин өрхийн орлогын төсөв тооцох аргачлал боловсруулсан бөгөөд үүнийгээ жишээгээр тайлбарлан авч үзье.

#### **Чинээлэг малчин өрхийн орлогын төсөв**

III.3.3.7 Чинээлэг өрхийг дунджаар 10 тэмээ, 25 адуу, 25 үхэр, 125 хонь, 125 ямаатай буюу нийт 310, түүнээс дээш малтай гэж тооцвол:

1. 10 тэмээнээс жилд 45 кг ноолуур авна.

2. 25 адуунаас жилд 6.5 кг хөөвөр, 2.3 ширхэг арьс, 319 кг мах, 595 литр айраг зэрэг түүхий эд авч ашигласнаар 304,300.0 төгрөгийн орлого олно.
3. 25 үхэрнээс 6.8 кг хөөвөр, 3.5 ширхэг арьс, 542.5 кг мах, 2555 литр сүү авч ашигласнаар 865,175.0 төгрөгийн орлого олно.
4. 125 хониноос 162.5 кг ноос, 25 ширхэг арьс 600 кг мах, 462.5 литр сүү авч ашигласнаар 479,375.0 төгрөгийн орлого олно.
5. 125 ямаанаас 30 кг ноолуур, 1.3 кг хялгас, 25 ширхэг арьс 380 кг мах, 862.5 литр сүү авч ашигласнаар 924,625.0 төгрөгийн орлого олно.

III.3.3.8 Нийт 310 малаас жилдээ 2,572,150.0 төгрөгийн орлого олж байгаагаас адуунаас олох орлого 11.8% , үхэрнээс олох орлого 33.6%, хониноос олох орлого 18.6%, ямаанаас олох орлого 35.9% эзэлж байна.

III.3.3.9 Тоогоор тэнцүү ч адуу үхэр хоёрын олох орлогын хэмжээ ялгаатай байгаа нь үхэр илүү таваарлаг, мөн хониноос ямаа илүү орлого /ноолуур/ олох боломжтой байдаг. Сарын борлуулалтын дундаж орлого нь 286 мянгаас илүү байгаа нь 4-6 ам бүлийг тэжээгээд, хуримтлал үүсгэж байдгийг баталж байна.

#### **Дундаж малчин өрхийн орлогын төсөв /төгрөгөөр/**

III.3.3.10 Дундаж айлыг 5 тэмээ, 15 адуу, 15 үхэр, 85 хонь, 85 ямаатай буюу нийт 150-250 толгой малтай гэж тооцвол.

1. Тэмээнээс /5/ 22.5 кг ноос,
2. Адуунаас /15/ 3.9 кг хөөвөр, 1.4 ширхэг арьс, 191.4 кг мах, 357 литр айраг авч ашигласнаар нийт 182580 төгрөгийн орлого олох боломжтой,
3. Үхэрнээс 4.1 кг хөөвөр 2.1 ширхэг арьс, 325.5 кг мах, 1533 литр сүү, авч ашигласнаар нийт 519105 төгрөгийн орлого олох боломжтой,
4. Хониноос 110.5 кг ноос, 17 ширхэг арьс, 408 кг мах, 314.5 литр сүү авч ашигласнаар 325975 төгрөгийн орлого олох боломжтой,
5. Ямаанаас 20.4 кг ноолуур, 0.9 кг хялгас, 17 ширхэг арьс 258.4 кг мах, 586.5 литр сүү, 85 гогцоо өлөн өвч ашигласнаар нийт 1655610 төгрөгийн орлого олох боломжтой.

III.3.3.11 Нийт орлогод адуу 11%, үхэр 31.4%, хонь 19.7%, ямаа 38 %-ийг тус тус эзлэж байна. Сарын борлуулалтын дундаж орлого нь 184 мянга байгаа нь 4-6 ам бүлийн зардал 150 мянган төгрөгийг төлөөд хуримтлал 30 мянган төгрөг үлдэж байна.

#### **Ядуувтар малчин өрхийн орлогын төсөв**

III.3.3.12 Ядуувтар өрхийг 1 адуу, 5 үхэр, 15 хонь, 15 ямаатай буюу нийт 36 толгой малтай гэж тооцоолбол.

1. Адуунаас 0.3 кг хөөвөр, 0.1 ширхэг арьс, 12.8 кг мах, 23.8 литр айраг ашиглаж 12172 төгрөгийн орлого,
2. Үхэрээс /5/ 1.4 кг хөөвөр, 0.7 ширхэг арьс, 108.5 кг мах, 511 литр сүү авч ашигласнаар 173035 төгрөгийн орлого,

3. Хонионоос /15/ 19.5 кг ноос, 3 ширхэг арьс, 72 кг мах, 55.5 литр сүү авч ашигласнаар 57525 төгрөгийн орлого,
4. Ямаанаас /15/ 3.6 кг ноолуур, 0.2 кг хялгас, 3 ширхэг арьс, 45.6 кг мах, 103.5 литр сүү, 15 /гог/ өлөн авч ашигласнаар 110955 төгрөгийн орлого ба жилдээ 353526 төгрөгийн орлого олох боломжтой юм.

III.3.3.13 Нийт орлогод адуу 3.4%, үхэр 48.9%, хонь 16.3%, ямаа 31.4 хувийг тус тус эзэлж байна.

III.3.3.14 Сарын борлуулалтын дундаж орлого нь 40 мянган төгрөг байгаа нь 4 ам бүлийн зардал 118 мянган төгрөгийг төлөөд хасах буюу өртэй байна. Өрхийн сарын орлого 40 мянган төгрөг байгаа нь тухайн өрхөд 2 хөдөлмөрийн насны хүн байгаа гэж үзвэл тус бүрийн орлого 20 мянган төгрөг болж энэ нь амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч байна гэсэн ойлголт юм.

### **III.3.4 Хөрөнгөө эргэлтэнд оруулах эдийн засгийн сэтгэлгээ**

III.3.4.1 Малчдын хөрөнгийн ойлголт, хөрөнгөө эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар ямар бодолтой байгааг үнэлэх зорилгоор *"Танай нутагт үйлдвэр барьж, малчдад малаасаа зарж хөрөнгө оруулж, уг үйлдвэрийн хувьцаа эзэмших боломж гарвал Та ямар шийдвэр гаргах вэ?"* гэсэн асуулт тавьсан. Энэ асуултанд нийт малчдын 53,3% нь хөрөнгө оруулна гэж хариулжээ. 1.5% нь хөрөнгө оруулахгүй, 16.6% нь эргэлзэж байгаагаа илэрхийлж, 27.5% нь мэдэхгүй байна гэж хариулсан байна.

III.3.4.2 Малчид мал маллахын зэрэгцээ өөр үйл ажиллагаанд хөрөнгө оруулах, үүнээс ашиг олохыг сонирхож байгаа ч цөөн малтай малчид нилээд их байна. Мөн бусдыг дагах, байдлыг харсан зан хэвээрээ байна.

III.3.4.3 Мал аж ахуйн өгөөжийг нэмэгдүүлэх талаар нээлттэй санал асуулгаар малчдын идэвхи, санаачлагыг тодорхойлж үнэлэх зорилт дэвшүүлсэн бөгөөд Одоогоор юу ч хийгээгүй 53.4%, Малын үүлдэр угсааг сайжруулах хэрэгтэй 32.3%, Оторлох 4.3%, Эрчимжсэн мал ахуйтай болох 7.8%, Малыг эрүүлжүүлэх ажил хийж байгаа 1.6%, Бэлчээр ашиглалтыг сайжруулж байгаа 0.5%, Хоршиж ажиллах 0.1% гэж хариулсан. Энэ асуултанд малчдын хариулсан байдлаас үзэхэд малчдын нэлээд хувь нь буюу 53,4% мал аж ахуйн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар тодорхой зүйл санаачлахгүй байгаа нь харагдаж байна.

III.3.4.4 Малчдын 32,3% нь малын үүлдэр угсааг сайжруулах талаар бодож байна. Малчид малынхаа үүлдэр угсааг сайжруулах замаар үр ашгаа нэмэгдүүлнэ гэж үздэгтэй энэ нь холбоотой юм. 7,8% нь мал аж ахуйг эрчимжүүлэх тал дээр анхаарч байгаагаа тэмдэглэжээ.

III.3.4.5 Мал аж ахуйг эрчимжүүлэх, өндөр үр өгөөжтэй болгоход малчдын багагүй хэсэг нь санаа тавьж ажиллаж байна.


III.3.4.6 **Хөрөнгөө эдийн засгийн эргэлтэнд оруулж байгаа малчдын туршлага-ыг Хавсралт № 4-д үзүүлэв.**



## III.4 ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

### III.4.1 Хамтран ажиллах хэрэгцээ шаардлага

III.4.1.1 “Хоршин ажиллах ямар хэлбэрийг сонгох вэ?” гэсэн асуултанд малчдын ихэнх нь түүхий эдээ хамтарч борлуулах гэж 47,4% хариулсан нь Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ ганцаараа эсвэл ченжүүдэд худалдах хэлбэрээр борлуулдагаа больж нийлж хамтарч борлуулах нь ашигтай хувилбар гэж үзэх хандлага байна.



III.4.1.2 Мөн хөдөлмөрөө нэгтгэх 26.2%, хамтарч жижиг үйлдвэрлэл явуулна гэж 28.1% нь хариулсан байна. Малчдын 23.3% хадгаламж зээлийн хоршооны хэлбэрийг хамтран ажиллах хувилбар болгон сонгожээ. Ердөө 0.17% нь мэдэхгүй гэж хариулжээ.

#### Хорших сонирхол ба насны ялгаа

III.4.1.3 Малчдын хувьд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ зах зээлд өндөр үнээр борлуулах хэлбэрээр хамтарч ажиллах сонирхол давамгайлж байхын зэрэгцээ насны онцлог харагдаж байлаа. Тухайлбал,

20 хүртэл насныхан хадгаламж зээлийн хоршоонд элсэх;

21-30 насныхан хамтарч жижиг үйлдвэрлэл явуулах;

31-40 насныхан өргөн хэрэглээний барааны хангамжаа бөөний үнээр авах;

41-50 насныхан хамтарч жижиг үйлдвэрлэл явуулах;

51-ээс дээш насныхан хөдөлмөрөө нэгтгэх (хашаа хороо, худаг барих, өвс тэжээл бэлтгэх) саналыг илүү өгсөн байна.

III.4.1.4 Малчдын хорших хамтран ажиллах хэрэгцээг 1. Түүхий эд бүтээгдэхүүнээ нийлж, зах зээлд өндөр үнээр борлуулах, 2. Өргөн хэрэглээний барааны хангамжаа нийлж, бөөний үнээр авах, 3. Хадгаламж зээлийн хоршоонд элсэх, 4. Хамтарч жижиг

үйлдвэрлэл явуулах /эсгий, модон эдлэл гэх мэт/, 5. Хөдөлмөрөө нэгтгэх /хашаа хороо, худаг барих, өвс тэжээл бэлтгэх/ гэсэн 5 бүлэг асуултаар авсан.<sup>2</sup>

**III.4.1.5** Хорших хамтрах хэрэгцээний хамгийн их эрэлттэй байгаа нь “Түүхий эд бүтээгдэхүүнээ нийлж, зах зээлд өндөр үнээр борлуулах” байв. Эдгээр хэлбэрүүдийг малчдын нас, эзэмшсэн боловсрол, өрхийн ам бүлтэй харьцуулан бодож үзэхэд онцын их ялгаа гарсангүй. Харин малын төрөл, тоотой харьцуулан бодоход малын төрлөөс үл хамааран, тоотой хамаарал бүхий хандлага ажиглагдлаа.

**III.4.1.6** Жишээлбэл, Малчин өрхийн үхрийн тоогоор бүлэглэсэн үзүүлэлтийг хорших хэлбэртэй харьцуулахад түүхий эд бүтээгдэхүүнээ нийлж борлуулах саналд дундаж өрхүүд /11-ээс 50 хүртэл үхэртэй/ илүү санал өгч байна. Энэ нь Чинээлэг өрхүүд өөрсдөө зах зээлд аваачиж борлуулж, ядуу өрхүүд “барааны зээл”-ийн өрөнд өгөх, эсвэл бүтээгдэхүүнээ үнэ хүргэх талаар төдийлөн санаачилдаггүйтэй холбоотой юм.

### Хүснэгт 10 Хорших хэлбэр ба амьжиргааны түвшин

Хорших хэлбэр	Ядуувтар	Дундаж	Чинээлэг
Түүхий эд бүтээгдэхүүнээ нийлж зах зээлд өндөр үнээр борлуулах	32.5%	38.7%	29.0%
Өргөн хэрэглээний барааны хангамжаа нийлж, бөөний үнээр авах	16.4%	16.0%	16.1%
Хадгаламж зээлийн хоршоонд элсэх	14.4%	10.4%	16.1%
Хамтарч жижиг үйлдвэрлэл явуулах /эсгий, модон эдлэл гэх мэт/	19.0%	14.7%	25.8%
Хөдөлмөрөө нэгтгэх /хашаа хороо, худаг барих, өвс тэжээл бэлтгэх/	17.8%	20.2%	12.9%
Нийт	100%	100%	100%

**III.4.1.7** Малчдын гол орлого нь МГТЭ-ээ бэлтгэж, түүнийгээ үнэ хүргэж борлуулах явдал тул амьжиргааны 3 түвшингийн малчид бүгд “Түүхий эд бүтээгдэхүүнээ нийлж зах зээлд өндөр үнээр борлуулах”, мөн ХӨХБ-ны хангамжаа нийлж, бөөний үнээр авах дээр нийтлэг хандлагатай байна.

**III.4.1.8** Хадгаламж зээлийн хоршоонд элсэх болон жижиг үйлдвэрлэл эрхлэх талаар Чинээлэг өрхүүд илүү санал өгсөн нь хөрөнгийн боломжтой, нөгөөтэйгүүр хөрөнгөө эргэлтэнд оруулах талаар илүү санаачлагатай байгааг харуулж байна.

**III.4.1.9** Хөдөлмөрөө нэгтгэх талаар дундаж, ядуувтар өрхүүд илүү санал өгсөн нь хамтын хөдөлмөрийн давуу талыг үнэлж, ахуйгаа хамтын хөдөлмөрөөр эрхлэх сонирхол их байгааг харуулж байна.

**III.4.1.10** Амьжиргааны түвшин ядуувтар өрхүүд мал цөөтэй боловч ам бүл харьцангуй олон тул бусдын байгуулсан жижиг үйлдвэрлэлд хөлсний ажил хийж, нэмэгдэл орлого олох сонирхол нь “Хамтарч жижиг үйлдвэрлэл явуулах” гэсэн

<sup>2</sup> Эдгээр хэлбэрүүдийг хамгийн их хариулт өгсөн байдлаар нь эрэмблэн байрлуулав.

хэлбэрийг II. хашаа хороо барих, өвс хадах, мал маллах зэрэг хөдөлмөрөөрөө хорших хэлбэрийг III тавьж байна. ХӨХБ-гаа хямд худалдаж авах, мөн түүндээ зориулж ХЗХ–ноос зээл авах хэлбэрүүдийг сонгож байна.

**III.4.1.11** Дундаж амьжиргааны түвшний өрхүүд мал маллагаандаа түлхүү анхаарч, түүнийгээ бэхжүүлэх, тогтворжуулах болон мал аж ахуйн эрсдлийг багасгах үүднээс “Хөдөлмөрөө нэгтгэх” хэлбэрт удаахь ач холбогдлыг өгчээ. Энэ нь тэдний орлого ихэвчлэн хоол хүнс, ахуйн хэрэглээнээсээ илүү гардаггүйтэй холбоотой байна. ХӨХБ-гаа хямд авах замаар өрхийн зардлаа багасгах, цагаан идээ боловсруулах, оёдол хийх, модон эдлэл хийх зэрэг хөрөнгө оруулалт бага шаардах өрхийн үйлдвэрлэл эрхлэх болон ахуйн хэрэгцээ, мал аж ахуйдаа зээл авах сонирхолтой байна.

**III.4.1.12** Чинээлэг өрхүүд МГТЭ-ээ үнэ хүргэж борлуулах, эсгий хийх, арьс шир боловсруулах зэрэг жижиг үйлдвэрлэлд хөрөнгө оруулахыг илүүтэй чухалчилсан байна. Ахуйн хэрэглээний бараа, үйлдвэрлэлийн түүхий эдийг хямд үнээр олж авах, ХЗХ-гоор дамжуулан ХНХ хэлбэрээр хуримтлалаа өсгөх, эцэст нь мал оторлох зэргээр хорших хэлбэрийг сонирхдог байна.

**Хүснэгт № 11** Малчдын хамтрах хэрэгцээг амьжиргааны түвшинтэй нь уялдуулсан үнэлгээ

Үзүүлэлтүүд	Амьжиргааны түвшин		
	Ядуувтар	Дундаж	Чинээлэг
Өрхийн орлого, зарлагын баланс	Хасах /-70 мян.төг/	Баланс /-30-аас 30 мян.төг/	Хуримтлал /+70 мян.төг/
Зээлийн зориулалт	Ахуйн зээл	Жижиг үйлдвэрлэл, Мал маллагаа	
Зээлийн хэмжээ	100-300 мян.төг	300-500 мян.төг	1-3 сая
Зээлийн барьцаа хөрөнгө	Байхгүй	Мал	Мал, үнэт эдлэл, Өвөлжөө
Өрхийн тооцоо	Хийдэггүй	Зарим хэсэг	Хийдэг
Сурч боловсрох сонирхол	Сонирхолтой	Сонирхолтой	Сонирхолтой
Хамтран ажиллах	Хөдөлмөрөөр		Хөрөнгө /ХЗХ, Жижиг үйлд/

**III.4.1.13** *Хоршоо байгуулахад ямар туслалцаа хэрэгтэй байна вэ?* гэсэн асуултын хариултаас үзэхэд малчдын 12.9% нь хоршоог дээрээс дэмжих, 21.5% банкны зээл олгох, 21.5% мөнгөөр дэмжих, 16.6% хоршооны сургалт, 15.4% малчид хоорондоо санаа нийлж ажиллах гэж тус, тус хариулсан нь нэг талаар бодлогын зохицуулалт дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгааг, нөгөө талаар малчид өөрсдөө санаачилга гаргаад ажиллах чадвар дутагдаж байгааг харуулж байна.

**III.4.1.14** Хоршоо байгуулахад ямар туслалцаа хэрэгтэй байна гэсэн асуултанд ихэнх нь дээрээс зохион байгуулах, банкны зээл олгох, мөнгөн тусламж үзүүлэх гэж хариулсан нь малчид хуучны үзэл баримтлалаасаа бүрэн салаагүй, бэлэнчлэх сэтгэлгээ нь хэвээр байгааг харуулж байна. Өөрсдийн нөөц боломжийг дайчлаад

---

хоорондоо санаа нийлээд, зөвлөгөө аваад хоршоо байгуулбал болно гэдэгт итгэлтэй малчид цөөнгүй байлаа.

III.4.1.15 Харин хоршоог нь дээрээс нь байгуулаад өгвөл зарим малчид энэ чинь хуучны нэгдэл гэсэн ойлголтоор хандаж магадгүй учир дотроосоо санал гаргаад байгуулбал илүү үр дүнтэй болов уу. Малчдад хоршоо байгуулж ажиллахад хөрөнгө мөнгөний дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хоршоо байгуулах, цаашид үүнийгээ удирдаж авч явахад шаардагдах мэдлэг олгох, мэдээлэл хүргэх сургалт зохион байгуулах хэрэгтэй болох нь дээрх асуултанд өгөгдсөн хариултуудаас харагдаж байна.

III.4.1.16 Нөгөө талаас дээрх асуултыг малчдын үйл ажиллагааг дэмжихэд орон нутгийн төрийн байгууллагын оролцоо, зохицуулалт хэр шаардлагатай байгааг тандах зорилгоор тавьсан болно. Малчид өөрсдөө хэдий их хичээсэн ч орон нутгийн ЗДТГ, ИТХ-аас зах зээлийн орчин бүрдүүлэх, иргэдийн идэвхтэй ажиллах, амьдрах хүсэл сонирхол санаачлагыг дэмжиж ажиллахгүй бол төдий л амжилт гарахгүй байгаа нь харагдаж байлаа.

III.4.1.17 Завхан аймгийн Дөрвөлжин, Хэнтий аймгийн Галшир, Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа зэрэг сумын ЗДТГ, ИТХ-ийн орон нутаг, иргэддээ хандсан үйл ажиллагаа явуулах, малчдын болон бусад хоршоог дэмжин хөгжүүлж байна. Гэтэл малчид нь идэвхийлэн санаачилж байхад удирдлага нь дэмжихгүй, санаачлага гаргасан малчдыг хөрөнгөжиж, хүний хөдөлмөр завшиж байгаа мэтээр сурталчилж байгаа сумын зах зээлийн болон иргэдийн амьжиргаа доогуур байна.

### **Хоршооны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ /санал асуулгаар/**

III.4.1.18 Судалгаанд оролцогчдын 27.1% нь хоршооны гишүүн, 72.9% нь хоршооны гишүүн бус байлаа.

III.4.1.19 Судалгаанд хамрагдаж хоршооны гишүүн гэж хариулсан малчдын 12.7% нь өнөөгийн хоршоог хуучин нэгдлийн суурин дээр үүссэн хоршооноос ялгахгүй байна, 32.8% нь зах зээлийн нөхцөлд таарсан хоршоо, 48.7% нь мэдэхгүй, 0.1% нь дампуурсан гэж дүгнэсэн байна.

III.4.1.20 Малчид хоршооны үйл ажиллагаа сайн хүртээмжтэй гэж 13.5%, дунд зэрэг гэж 36.9%, муу гэж 49.5% тус, тус хариулсан нь хоршооны үйл ажиллагааны талаар малчид итгэл бага буюу хамтран ажиллах талаар сул байгаа хандлага давамгайлжээ. Өөрөөр хэлбэл орон нутагт ажиллаж байгаа хоршооны үйл ажиллагааг сайжруулах, цаашид боловсронгуй болгох шаардлагатай гэдгийг дээрх үнэлгээ харуулж байна.

**Хүснэгт № 12 Хоршооныхоо талаархи үнэлгээ**

<b>Хоршооны талаархи үнэлгээ</b>	<b>Муу</b>	<b>Дунд</b>	<b>Сайн</b>
Түүхий эдийг үнэ хүргэх талаар	58.1%	29.7%	12.3%
Хүнс барааны чанар	39.2%	48.0%	12.7%
Хүнс барааны үнэ	44.6%	40.5%	15.0%
Малчиддаа хүрч үйлчлэх талаар	55.9%	28.6%	15.4%
Хот хөдөөг холбох талаар	56.9%	33.2%	9.9%
Удирдлагын арга ажиллагаа	42.5%	41.6%	15.9%
<i>Дундаж</i>	<i>49.5%</i>	<i>36.9%</i>	<i>13.5%</i>

III.4.1.21 Орон нутагт мал маллагааны /хадлан тэжээл авах, оторт явах/ зэргээр хөдөлмөрөө хоршин ажиллаж ирсэн туршлага байгаа ч хөрөнгөөр /малаар/ хорших талаар болгоомжилсон, хүлээсэн байр суурьтай байна.

III.4.1.22 Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ хамтран борлуулах талаар хорших сонирхол их /32,5%/ байгаа ч энэ нь улирлын чанартай, мөн “зээл”-ийн сэтгэлгээ нь хоршоогоо эргэлтийн мөнгөгүй байдалд оруулж байна.

III.4.1.23 Малчид хоршин хамтран ажиллах хэрэгцээгээ улам бүр мэдэрч байгаа ч төдийлөн амжилт олж чадахгүй байгаа нь

1. Малчдын эдийн засгийн боловсрол,
2. Малчид өмчийн харилцаанд оролцохоос болгоомжилж байгаа,
3. Хоршин хамтрахад нь эрх зүйн болон удирдлагын арга ажиллагаа дутагдаж байгаатай холбоотой байна.

### **III.4.2 Хөдөөгийн хоршооны хэлбэр, онцлог (жишээгээр)**

III.4.2.1 Суман дахь өнөөгийн хоршооны хэв шинж, гишүүддээ болон сумын эдийн засагт үзүүлж буй нөлөөг үнэлэх зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Говь-Алтай аймгийн Дарви сумдын хоршоодыг жишээ болгон судлав.

#### À. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын "Өгөөж баян Улаан" хоршоо

Нэгдлийн худалдаа бэлтгэлийн ангийн суурин дээр үүссэн хувьцаат компани, энэ хэв шинжээс хоршооны хэлбэрт 1999 оноос шилжсэн байна. Тус хоршоо нь хангамж, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг, эргэлтийн болон үндсэн хөрөнгө нөөцтэй, үйл ажиллагаагаараа улсад шалгарч байсан томоохон хоршоо байсан. Өнөөгийн байдлаар хоршооны эдийн засаг суларч, үйл ажиллагаа зогсонги байдалд орж улмаар сумандаа бусад жижиг аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй өрсөлдөх чадвар нь багассан байна. Хоршооны удирдлага 2002 онд шинэчлэгдэж, хоршоогоо хөгжүүлэх шинэ гарц, арга замыг хайж байна.

#### В. Өвөрхангай аймгийн Төгрөг сумын "Өгөөж мандах" хоршоо.

Малчны бүлгийн хамтын үйл ажиллагаанаас 2003 онд шинээр хоршоо болон зохион байгуулагдсан байна. Энэ хоршоо нь газар зүйн хувьд нэг дор орших 10 малчин өрхийн хүрээнд, тэдний хамтын хүчийг нэгтгэн зохион байгуулж, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх замаар, Хөдөөд хагас суурин мал аж ахуйг хөгжүүлэх ба шилмэл омгийн мал үржүүлэх зорилготой жижиг хоршоо юм. Хоршоог үүсгэн байгуулахад "Говийн санаачлага" төслөөс техникийн туслалцаа үзүүлж байна. Малчдад зах зээлийн мэдлэг олгох, малчны бүлгийн хамтын бизнес эрхлэх, Хоршоог байгуулах болон хоршооны хөгжлийн бизнес төлөвлөгөөг боловсруулах сургалтыг тодорхой үе шаттай явуулахад "Говийн санаачлага" төслөөс туслаж байна.

#### С. Өвөрхангай аймгийн Хархорин сумын "Гүнж Хар хорин" хоршоо

Гишүүдийн зээл санхүүгийн хэрэгцээг хангах зорилготой 2002 онд шинээр байгуулагдсан, хадгаламж зээлийн үйл ажиллагааг дагнан эрхлэж байна. Байгуулагдсан цагаасаа эхлэн үйл ажиллагааны цар хүрээ нь түргэн тэлж, өргөжиж байна.

#### Д. Говь-Алтай аймгийн Дарви сумын "Хужирт Жавхлант" хоршоо

Нэгдлийн суурин дээр байгуулагдсан хувьцаат компани /ХК/, түүнээс үүссэн хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-ны хэлбэрээс 1997 онд хоршооны хэлбэрт өөрчлөгдөн зохион байгуулагдсан хоршоо юм. Хоршоо Хангамж борлуулалт, зээлийн үйл ажиллагааг голлон эрхлэхийн зэрэгцээ ахуйн үйлчилгээ, усан хангамжийн үйлчилгээ явуулж байна. Гишүүнчлэлийн тоо, үйл ажиллагааны цар хүрээгээр манай улсын томоохон хоршоодын нэг юм.

#### Говь-Алтай аймгийн Дарви сумын "Бүян-Ундрал" компани

Нэгдлийн суурин дээр байгуулагдсан хувьцаат компаниас ХХК-ны хэлбэрт 1995 онд шилжэн зохион байгуулагдсан. Сумандаа хангамж борлуулалт, зээлийн чиглэлийн үйл ажиллагааг идэвхтэй эрхлэн явуулж байгаа үлгэр жишээ компани байна.

III.4.2.2 Дарви сумын “Хужирт Жавхлан” хоршоо ба “Буян–Ундрал” компани нь нэг суманд ижил төрлийн үйл ажиллагааг зэрэгцэн амжилттай явуулж байна. Энэ 2 аж ахуйн нэгж сумын нийт өрхийг бараг бүхэлд нь хуваан гишүүнчлэлдээ хамруулсанаас гадна сумын эдийн засагт гол нөлөө үзүүлж байгаа онцлогтой болно.

III.4.2.3 Хавсралт № 1-д **Өвөрхангай, Говь-Алтай аймгийн хоршоодын өнөөгийн байдал /№ 1.1/, эдийн засгийн үзүүлэлт /№ 1.2/, үйл ажиллагааны цар хүрээ /№ 1.3/-г зэрэгцүүлэн харуулав.**

III.4.2.4 Зүүнбаян-Улаан сумын “Өгөөж баян Улаан” хоршоо 1999 онд 607 гишүүнтэй жилдээ 20-иод сая төгрөгийн ашигтай ажиллаж, ХААХҮХ-оос жил бүр зарладаг уралдаанд удаа дараа 2-3 дугаар байр эзлэж байжээ. Тус хоршоо сумын иргэдийн 70 хүртэл хувьд хүрч үйлчилж, сумын хэмжээний МГТЭ-ийн 80 шахам хувийг бэлтгэн авч, ХӨХБ-гаар сумыг бараг бүхэлд нь хангаж байжээ.

III.4.2.5 Зах зээлийн хөгжлийн жамаар суманд худалдааны эрхлэгч өрсөлдөгчид /хувь хүн, жижиг худалдааны цэгүүд/ олноор бий болсноор Хоршооны үйл ажиллагааны цар хүрээ хумигдаж эхэлсэн байна. Хэрэглэгч- үйлчлүүлэгчдийн төлөөх өрсөлдөөнд хоршоо хуучин түнш гишүүддээ илүү ойр дотно хандсан үйлчилгээ үзүүлж, тэдэнд эдийн засгийн урамшуулал болон оновчтой хөшүүрэг олж хэрэглэж чадаагүйгээс хоршоогоор үйлчлүүлэгч гишүүдийн тоо эрс цөөрч, өнөөдөр үйл ажиллагаа нь бараг зогсонг байдалд оржээ. 2002 онд жилийн орлогын хэмжээ 18 сая төгрөг хүрч, хоршоо алдагдалтай ажилласан байна. Гишүүдээ татах эдийн засгийн хөшүүргийг хангалтгүй хэрэглэж, гишүүдийг идэвхижүүлэхэд удирдлагын арга барил дутагдсан болон хоршооны Бүх Гишүүдийн Хурлыг тогтмол хийдэггүйгээс гадна, хоршооны баримтлах зарчмыг орхигдуулсан нь үйл ажиллагаа зогсонги байдалд ороход ихээхэн нөлөөлсөн байна.

III.4.2.6 **Хоршооны энэ дүр төрх хуучин нэгдэл, худалдаа бэлтгэлийн ангийн суурин дээр үүссэн байгуулагдсан манай улсын олон хоршоодын нэг жишээ юм. Эдгээр хоршоодын хувьд зохион байгуулалт, менежмент, маркетингийн судалгааг газар дээр нь хийж, өөрчлөн шинэчлэх эсвэл тухайн хоршоог татан буулгаж сумдад шинэ хоршоо үүсэх нөхцөлийг бүрдүүлэх нь хойшлуулашгүй асуудал болж байна. Энэ ажлыг шуурхай эхлэхгүй бол хөдөөгийн иргэд малчдын хоршоонд итгэх итгэлд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.**

III.4.2.7 Төгрөг сумын “Өгөөж мандах” хоршоо нь гадаадын төслийн техникийн туслалцааны үр дүнд байгуулагдаж байна. АОУХА-ын “Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага” төслийн хүрээнд байгуулагдан 2 жил гаруй ажиллаж байгаа малчны бүлгээс хоршоо болон өөрчлөгдөж байгаа хоршооны нэг шинэлэг хэлбэр юм.

III.4.2.8 Тус төслөөс говийн 6 аймгийн 300 орчим малчны бүлгүүдийн мастер малчны сургалт, малчны бүлгийн бизнес, ноолуурын сургалт, хоршооны зэрэг сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Эдгээр сургалтын үр дүнд малчны бүлгийн гишүүд хамтран ажиллахад суралцаж, улмаар зарим хэсэг нь цаашид хоршоо болон ажиллах эхлэл тавигдаж байна.

III.4.2.9 Төгрөг сумын дээрх бүлгийн гишүүдээс хоршоо болон ажиллах санаачлага гаргасан тул уг бүлгийг “Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх” төслийн хүрээнд

хоршин ажиллах эхлэл тавигдаж байна. Хоршооны үндсэн үйл ажиллагаа нь шилмэл үржлийн мал өсгөх, бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглах замаар хагас суурин мал аж ахуйг хөгжүүлэх явдал бөгөөд ойрын 1-2 жилд үлгэр жишээ хоршоо болох зорилттой ажиллаж байна. (Уг хоршооны үйл ажиллагааны ба гишүүнчлэлийн цар хүрээг одоогоор тоймлох боломжгүй байна)

**III.4.2.10** Хавсралт № 2-д **Хоршоодын эдийн засгийн үзүүлэлтүүд**-ийг зэрэгцүүлэн харуулав.

**III.4.2.11** Хархорин сумын "Гүнж хархорин" хоршоо нь сүүлийн 3 жилд хөдөө орон нутагт шинээр олноор байгуулагдаж байгаа Хадгаламж зээлийн хоршооны нэг жишээ юм. Эхний ээлжинд гишүүд 500 мянган төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө /ХНХ/ хэлбэрээр хоршоондоо байршуулж, дүрмийн санг бүрдүүлэн үйл ажиллагаагаа эхэлжээ. Өнөөдөр 100 мянган төгрөгийн нөөцийн сантай болж, зээлийн үйлчилгээг голлон явуулж байгаа бөгөөд зохих журмын дагуу зээлийн эрсдэлийн санг байгуулан ажиллаж байна. Хоршоо байгуулагдсан 2002 оны эцэст хоршооны цэвэр ашиг 93.5 мянган төгрөг байгаа нь гишүүдийн ногдол ашгийг 18.1% болгожээ.

**III.4.2.12** **Сумдад, ялангуяа хүн ам төвлөрсөн суманд зээлийн хэрэгцээ их байдгаас хоршооны үйл ажиллагаа түргэн өргөжиж, гишүүнчлэлийн хүрээ хурдан өсөж байгаа бөгөөд цаашид зээлийн багцийн хэмжээг гадны эх үүсвэрээр нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.**

**III.4.2.13** Говь-алтай аймгийн Дарви сумын "Хужирт Жавхлант" хоршоо 520 гишүүнтэй бөгөөд гишүүдийнхээ бэлтгэдэг МГТЭ-ийг авч борлуулах, ХӨХБ-аар гишүүдээ хангах үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Гишүүдээс авсан МГТЭ-ийг төвлөрсөн зах зээл дээр болон хил худалдаагаар өндөр үнэ хүргэн борлуулсны үр дүнд гишүүддээ жилд 2 удаа үнийн зөрүү нэмж олгож, жилийн эцэст ногдол ашиг хуваарилаж байна. Гишүүдтэй байгуулсан түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний үнийн дүнгийн 80 хүртэл хувьд мөнгөн болон барааны зээл олгодог байна. Гишүүдээ эдийн засгийн аргаар урамшуулж, ажилласны үр дүнд Хоршооны дүрмийн сан жилд 9%, жилийн орлого 50%, нэг гишүүнд ноогдох хөрөнгө 10%-иар тус, тус өссөн байна.

**III.4.2.14** Говь Алтай аймгийн Дарви сумын "Буянт ундрал" компани 305 хөрөнгө оруулагч бүхий гишүүдтэй ХХК-ийн хэлбэрээр ажиллаж байна. (Компанийн тухай хуулиар ХХК-ын хөрөнгө оруулагчдын дээд хязгаар 51 байна) Гишүүн малчдаас түүхий эд авч борлуулан, эргээд хүнс барааны хангамж хийдэг байна. Мөн хөрөнгө оруулагчидтайгаа гэрээ байгуулан ажилладаг бөгөөд гэрээний үнийн дүнгийн 70 хүртэл хувьд нь зээл олгодог байна. Гэрээний үүргээ зөрчсөн гишүүний эзэмшил хөрөнгийн хэмжээг багасгаж тооцдог бөгөөд энэ хэмжээ 50%-иас доош болж гишүүний санал өгөх түдгэлзсэн нөхцөлд үнийн зөрүү авах эрхгүй болгодог механизм үйлчилдэг байна. Компаний дүрмийн сан жилд 25%, жилийн орлого 18.6%, цэвэр ашиг 20.1 %-иар тус, тус өссөн байна.



### **III.4.3 Хоршооны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ**

**III.4.3.1** Гишүүдийн бэлтгэсэн МГТЭ-ийг цуглуулан авах гол арга бол Хоршоо жил бүр гишүүдтэйгээ бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулах явдал болж байна.

**III.4.3.2** Гэрээний үүргийн биелэлтийг 2002 оны байдлаар харвал Дарви сумын "Хужирт Жавхлант" хоршоо 42%-тай, Дарви сумын "Буянт ундрал" компани 27%-тай, Зүүн баян Улаан сумын "Өгөөж баян Улаан" хоршоо 4%-тай байна.

**III.4.3.3** Түүхий эдийн нийлүүлэлтийг нэр төрөл бүрээр авч үзвэл Зүүнбаян-Улаан сумын "Өгөөж баян-Улаан" хоршооны нийлүүлэлт бүх нэр төрлөөр буурсан бол, Дарви сумын "Хужирт Жавхлант" хоршоо ба "Буянт ундрал" компанийн хувьд ноолуураас бусад түүхий эдийн нийлүүлэлт мөн буурсан байна. Энэ үзүүлэлт буурсны гол шалтгаан бол гишүүдийг хоршооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах арга механизм дутагдаж, эдийн засгийн хөшүүрэг хангалтгүй байгаагийн зэрэгцээ зарим тохиолдолд хоршооны зарчим мөрдөгдөхгүй байгаа магадлалтай.

**III.4.3.4** Зүүнбаян-Улаан сумын хоршооны хувьд хоршооноос гишүүдийг урамшуулах эдийн засгийн зөв хөшүүрэг олж хэрэглээгүй, хоршооны ашиг орлогоос гишүүдэд ногдох эдийн засгийн үр өгөөж жил бүр багассан, хоршоог эдийн засгийн аргаар удирдах оновчтой механизм дутагдалтай байсан болон хоршооны ардчилсан удирдлага ба бүх гишүүдийн хяналт алдагдснаас гишүүдийн хоршоонд итгэх итгэл суларч, үүнээс үүдэн гишүүдээс хоршоотойгоо ажиллах эдийн засгийн сонирхолгүй болжээ.

**III.4.3.5** Дарви сумын хоршоодын хувьд гишүүдийг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгон ашиглаж, хоршооноос гишүүдтэй харилцах эдийн засгийн харьцангуй боломжит механизмыг хэрэглэж, гишүүнчлэлийг өргөн хүрээнд байлгаж чадаж байгаа илүү давуу талтай ч мөн л гэрээний үүргийн биелэлт бодитой өсөхгүй харин буурах хандлага ажиглагдаж байна.

**III.4.3.6** МГТЭ-ийн нийлүүлэлт, тоо хэмжээний хувьд буурч байгаа нь гишүүдэд хоршооноос гадуур түүхий эдээ илүү үнэ хүргэж борлуулдаг өөр суваг байгааг харуулж байна. Мөн гишүүдийн нийлүүлж байгаа МГТЭ-ийн нэр төрөл цөөн байна.

**III.4.3.7** Дарвийн хоршоодод цаашид бусад борлуулалтын сувгийн давуу талыг судлах болон гишүүдийн нэг малаас авах түүхий эд ба ашиг шимийг бүрэн дүүрэн авч орлогыг нэмэгдүүлэх маркетингийн шинэ стратеги боловсруулах шаардлага тулгарч байна.

**III.4.3.8** Сумдын нийт өрхийн 28% нь "Өгөөж баян Улаан" хоршооных, 1% нь "Өгөөж мандах" хоршооных, 0.4% нь "Гүнж хархорин" хоршооных, 61% нь "Хужирт Жавхлант" хоршооных, 29% нь "Буянт ундрал" компани гишүүн өрх бүрдүүлж байна. Үүнээс Дарви сумын 2 аж ахуйн нэгжийн гишүүд нийлээд сумын нийт өрхийн 90% болж байна. Сумын хэмжээнд хоршооны гишүүн өрхийн эзлэх хувь нь хоршоодын гишүүнчлэл сумын иргэдийг ямар түвшинд хамарч байгааг харуулж байна.

**III.4.3.9** Дээрх хоршоодоос "Өгөөж мандах" хоршоо үйл ажиллагааны төрлөөсөө хамаарч гишүүнчлэл өргөжих нь харьцангуй хязгаарладмал байх магадлалтай. Харин бусад хоршооны хувьд гишүүнчлэл өргөжиж боломж өндөр байна.

**III.4.3.10** Сумын хэмжээнд бүхэлдээ олж байгаа нийт орлогын 70 гаруй хувийг МГТЭ-ийн борлуулалтын орлого бүрдүүлдэг байна. /Сумын орлогын бүтцээс харна уу/.

**III.4.3.11** МГТЭ-ийн нийт борлуулалтын орлого Зүүнбаян-Улаан суманд 884 448.7 мянган төгрөг, Төгрөг суманд 562 136.2 мянган төгрөг, Хархорин суманд 2 571 917.2 мянган төгрөг, Дарви суманд 393 541.9 мянган төгрөг байна.

**III.4.3.12** Өнөөгийн байдлаар сумдын МГТЭ-ийн боломжит орлогын 2.8% нь “Өгөөж баян Улаан” хоршоогоор, 0.02% нь “Өгөөж мандах” хоршоогоор, 10.9% нь “Хужирт Жавхлант” хоршоогоор, 18.3% нь “Буянт ундрал” компаниар тус тус дамжиж байна.

**III.4.3.13** Цаашид эдгээр хоршоодод үйл ажиллагаагаа өргөжүүлж, орлогоо 80– 90%-иар нэмэгдүүлэх асар их нөөц бололцоо байгаа бөгөөд нөгөө талаар энэ хэмжээнд хүрч ажиллахад өнөөгийн ажлын арга механизмаа улам боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

**III.4.3.14** *Дарви сумын хоршоод хөдөө орон нутагт байнга шаардлагатай байдаг зээлийн үйлчилгээг, хангамж борлуулалтын үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлж байгаа нь өнөөгийн энэ амжилтад хүргэх гол хөшүүрэг болсон байна. Энэ үйлчилгээг улам боловсронгуй болгон хөгжүүлэх нь хамгийн оновчтой арга зам болно. Үүний тулд илүү нарийн тооцоо хийж, бизнес төлөвлөгөө боловсруулсны үндсэн дээр гадны санхүүгийн эх үүсвэрийг үр дүнтэй ашиглаж болно.*

**III.4.3.15** Азийн Хөгжлийн Банкнаас баруун 4 аймагт хэрэгжүүлж байгаа хөдөөгийн бичил санхүүгийн үйлчилгээний хөтөлбөрт уг хоршоодыг хамруулах нь дээрх асуудлыг шийдвэрлэх хамгийн ойрын боломж юм.

**III.4.3.16** **Сумын нийгэм, эдийн засагт хоршооны үйл ажиллагааны төрөл, хэмжээ ихээхэн нөлөөтэй байна.**

**III.4.3.17** **Сумын газар зүй, байршил, байгаль цаг уур, малын төрөл бүтэц, аж ахуй эрхэлж ирсэн уламжлалт арга, иргэдийн амьжиргааны түвшин, хөдөлмөрч чанар зэрэг онцлогоос шалтгаалан сум бүр өвөрмөц байх боловч мал аж ахуй голлосон хөдөөгийн 308 сумдын<sup>3</sup> хувьд нийтлэг байх хоршооны хэлбэр бол МГТЭ-ийн борлуулалт ХӨХБ-ны хангамжийн бизнес бөгөөд үүнийг хадгаламж зээлийн үйлчилгээтэй хослуулах нь хамгийн тохиромжтой хувилбар болж байна.**

**III.4.3.18** Энэ чиглэлд харьцангуй туршлагажиж, амжилт олж байгаа нь Дарви сум байна. Дарви сумын хувьд цаашид МГТЭ-ийн бэлтгэл болон бичил санхүүгийн үйлчилгээний сумын дотоод зах зээлийг сумын гадаад орчноос хамгаалах, харин сум дотроо өрсөлдөөнийг дээрх компани, хоршооны хүрээнд чөлөөтэй явуулах бодлого баримтлах нь зүйтэй байна.


**III.4.3.19** Зүүнбаян-Улаан болон хоршооны талаар түүнтэй ижил төстэй байдалтай байгаа сумдын хувьд хоршооны нөхцөл байдлын судалгааг газар дээр явуулж, хоршооны бүрэн үнэлгээ (менежмент, маркетинги, санхүү, үйл ажиллагаа)-г хийж, гишүүдийн ардчилсан удирдлага бүх гишүүдийн хяналтыг бий болгож мөрдүүлэх, хоршооны эрхлэх гол бизнесд түшиглэн хоршооны үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, гишүүдийн эдийн засгийн сонирхолд тулгуурласан урамшууллын хөшүүрэг, эдийн засгийн арга механизмыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

<sup>3</sup> МУ-ын хэмжээнд 329 сумаас

## III.5 МАЛЧДЫН ЗЭЭЛИЙН ХЭРЭГЦЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

### III.5.1 Малчдын зээлийн хэрэгцээ, зориулалт, хэмжээ, хугацаа, барьцаа хөрөнгө

III.5.1.1 Малчдад зээл хэрэгтэй юу гэсэн асуултанд тийм 81,1%, үгүй 18.9% тус тус хариулсан. Малчид зээлээ ямар зориулалтаар ашиглах талаар судалсан дүнгээс үзвэл:




III.5.1.2 Хүнс өргөн хэрэглээний бараанд зарцуулна 110, мал аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулна 291, хүүхдийн сургалтын төлбөрт 78, машин мотоцикл техник хэрэгсэлд 91, худалдаа наймаа эрхлэнэ 224, газар тариалан эрхэлнэ 211, малын түүхий эд боловсруулна 125, түүхий эдээ борлуулна гэж 91 малчин тус, тус хариулсан байна.

III.5.1.3 Хамгийн их буюу 291 малчин авсан зээлээ мал аж ахуйн үйлдвэрлэлийн (өвс тэжээл, мал эмнэлэг, худаг хашаа хороо барих) зориулалтаар хэрэглэнэ гэсэн байхад 221 хүн газар тариалан эрхэлнэ гэжээ. **Малчдын дунд мал маллахын зэрэгцээ хавсарсан аж ахуй эрхлэх сонирхол байгаа нь илэрхий байна.**


III.5.1.4 Зээл хэрэгтэй гэсэн 812 малчны 4.4% нь 100 мянга хүртэл, 10.6% нь 101-300 мянга, 22.0% нь 301-500 мянга, 31.2% нь 501-1 сая, 22.0% нь 1-3 сая, 4.1% нь 3-5 сая, 5.7% нь 5 саяас дээш хэмжээтэй зээл авах хэрэгцээтэй гэж хариулсан байна.

III.5.1.5 Зээлийн тохиромжит хэмжээ 300-500, 500 мянгаас 1 сая хүртэл төгрөг байна.




III.5.1.6 Малчдын 2.9% нь 1-3 сар, 15.8% нь 3-6 сар, 31.3% нь 6-12 сар, 22.6% нь 1-1.5 жил, 12.6% 1.5-2 жил, 14.7% нь 2 жилээс дээш хугацаатай зээл хэрэгтэй гэсэн хариулт өгсөн.

Хариултаас үзэхэд малчид дунд хугацааны 6-12 сар, 1-1.5 жил зээлийг




тохиромжтой гэж үзэж байна.




**III.5.1.7** Малчид зээлийн барьцаанд малаа /539/, үнэт эдлэлээ /150/, тээврийн хэрэгсэл /251/, тоног төхөөрөмж /43/, өвөлжөө хаваржаа /204/, сумын төвийн хашаа байшин /228/, ногооны газар /45/, түүхий эд /179/ барьцаална гэж тус тус хариулжээ.

**III.5.1.8** Малчид зээлийн барьцаанд мал, өвөлжөө хаваржааны байшин, үнэт эдлэл өгөх сонирхол түлхүү байна. Энэ нь малчдын хувьд зээлийн барьцаанд өгч чадах бодит хөрөнгө юм . Мөн түүхий эдээ барьцаалж зээл авах сонирхол их байгаа нь харагдаж байна.

**III.5.1.9** 1000 малчдаас 496 нь урьд зээл авч байгаагүй, 248 нь ХААН банкнаас зээл авч байсан, 53 нь ХАС банкнаас зээл авч байсан, 43 нь бусад банк ба банк бус санхүүгийн байгууллагаас зээл авч байсан гэж хариулсан.



**III.5.1.10** Зээл авч байсан малчдаас зээлийн нөхцлийн талаар 17.4% нь сайн, 26.6% нь дунд зэрэг, 12.0% нь тааруу гэж үнэлсэн байхад 44,1% нь хариулт өгөөгүй. Зээлийн нөхцлийн талаарх малчдын сэтгэгдэл төдийлэн сайнгүй байна. Зээл авч байсан хүмүүсийн 38,6% нь зээлийн нөхцөл дунд болон тааруу гэсэн үнэлгээ өгсөн нь үүнийг бүрэн илэрхийлж байна.



**III.5.1.11** Малчдын 45.2% нь зээлийн хүүг бууруулах, 17.5% нь зээлийн хугацааг уртасгах, 2.6% нь үндсэн зээл төлөх нөхцөл, 2.4% нь хүү төлөх нөхцөл, 0.2% нь зээлийн хэмжээ, 3.5% нь зээлийн барьцааны хэлбэрийг өөрчлөх шаардлагатай гэж хариулжээ.

**III.5.1.12** Малчид 6 сараас 1 жилийн хугацаатай, 2-3 хувийн хүүтэй 300 мянгаас 1 сая төгрөгийн зээл авах сонирхолтой байна.

### Хүснэгт 13 Зээлийн хэмжээ, зориулалтын харьцаа

Зээлийн зориулалт	Зээлийн хэмжээ							Дүн
	100 мянга хүртэл	101-300 мянга	301-500 мянга	501-1 сая	1-3 сая	3-5 сая	5 саяас Дээш	
Хүүхдийн сургалтын төлбөрт	8	18	21	14	10	3	1	75
Малын гаралтай түүхий эдээ борлуулахад гарах зардалд	3	8	15	29	24	3	5	87
Машин мотоцикл, шинэ гэр, цахилгаан үүсгүүр, зурагт сансрын	1	8	23	33	19	3	1	88
Хүнс, ахуйн хэрэглээний бараа худалдаж авна	8	14	20	38	10	10	3	103
Малын түүхий эд боловсруулах бага оврын техник, тоног төхөөрөмж	2	2	22	29	44	6	14	119
Газар тариалан эрхэлнэ /хүнс ногоо, малын тэжээл тариалах/	6	22	27	73	46	7	18	199
Худалдаа наймаа эрхлэх	7	13	45	66	66	8	9	214
Мал аж ахуй үйлдвэрлэлийн /өвс тэжээл, мал эмнэлэг, худаг хашаа/	14	29	72	103	36	13	14	281
<b>Дүн</b>	49	114	245	385	255	53	65	

III.5.1.13 Хүүхдийн сургалтын төлбөрт зориулсан зээлийн хэмжээ 100 мянгаас 500 мянга хүртэл, Малын гаралтай түүхий эдээ борлуулахад гарах зардалд зориулсан зээлийн хэмжээ 300 мянгаас 3 сая, Машин мотоцикл, шинэ гэр, цахилгаан үүсгүүр, зурагт сансрын антени авахад зориулсан зээлийн хэмжээ 300 мянгаас 1 сая хүртэл, Хүнс, ахуйн хэрэглээний бараа худалдаж авах зээлийн хэмжээ 100 мянгаас 1 сая хүртэл, Малын түүхий эд боловсруулах бага оврын техник, тоног төхөөрөмж худалдан авах 300 мянгаас 3 сая хүртэл, Газар тариалан, хүнс ногоо, малын тэжээл бэлтгэх зээлийн хэмжээ 100 мянгаас 3 сая хүртэл, Худалдаа наймаа эрхлэх зээлийн хэмжээ 300 мянгаас 3 сая хүртэл, Мал аж ахуй үйлдвэрлэлийн /өвс тэжээл, мал эмнэлэг, худаг хашаа бэлтгэх/ зээлийн хэмжээ 100 мянгаас 3 сая хүртэл тус тус байх нь зохимжтой байна.

**Хүснэгт 14** Зээлийн хугацаа, зориулалтын харьцаа

Зээлийн зориулалт	Зээлийн хугацаа						Дүн
	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-1,5 жил	1,5-2 жил	2 жилээс дээш	
Хүүхдийн сургалтын төлбөрт	5	8	28	13	6	12	72
Машин мотоцикл, шинэ гэр, цахилгаан үүсгүүр, зурагт сансрын антени	2	22	15	12	17	12	80
Хүнс, ахуйн хэрэглээний бараа худалдаж авна	4	15	40	14	14	12	99
Малын түүхий эд боловсруулах бага оврын техник, тоног төхөөрөмж	6	12	27	27	22	16	110
Малын гаралтай түүхий эдээ борлуулахад гарах зардалд	5	35	16	17	14	87	174
Худалдаа наймаа эрхлэх	6	47	58	53	23	21	208
Мал аж ахуй үйлдвэрлэлийн /өвс тэжээл, мал эмнэлэг, худаг хашаа/	9	39	91	50	28	50	267
Газар тариалан эрхэлнэ /хүнс ногоо, малын тэжээл тариалах/	28	56	57	19	31	191	382
Дүн	65	234	332	205	155	401	

III.5.1.14 Хүнс ахуйн хэрэглээний бараа худалдаж авах зээлийн дундаж хугацаа 6-12 сар, Мал аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулах 3-6 сар, Хүүхдийн сургалтын төлбөрийн зээлийн хугацаа 6-12 сар, Машин, мотоцикл, цахилгааны үүсгүүр худалдаж авах зээлийн хугацаа 3-12 сар, Худалдаа наймаа эрхлэх зээлийн хугацаа 3 сараас 1,5 жил, Газар тариалан эрхлэх зээлийн хугацаа нь 3-12 сар, Малын түүхий эд боловсруулах бага оврын техник, тоног төхөөрөмж авах зээлийн хугацаа 6 сараас 2 жил хүртэл байвал зохистой байна.

**Хүснэгт № 15** Зээлийн хугацаа, хэмжээний харьцаа

Зээл хэмжээ	Зээлийн хугацаа						Нийт
	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-1,5 жил	1,5-2 жил	2 жилээс дээш	
100 мянга хүртэл	5	12	6	6	1	5	35
101-300 мянга	5	27	31	7	4	3	77
301-500 мянга	10	36	69	28	7	13	163
501-1 сая	-	27	90	56	25	36	234
1-3 сая	1	10	23	58	43	29	164
3-5 сая	-	2	2	6	10	10	30
5 саяас дээш	1	1	5	12	2	22	43
Нийт	22	115	226	173	92	118	746



III.5.1.15 Зээлийн хэмжээ бага байхад зээлийн хугацаа богино, зээлийн хэмжээ их болох тусам хугацаа уртсаж байгаа зүй тогтол харагдаж байна.

Зээлийн хэрэгцээг малын тоотой харьцуулсан үнэлгээ

III.5.1.16 Зээлийн хэрэгцээг малын тоотой харьцуулан үзвэл: 10 хүртэл үхэртэй 322 өрх, 11-30 үхэртэй 139 өрх, 31-50 үхэртэй 38 өрх, 51-100 үхэртэй 15 өрх, 101-200 үхэртэй 16 өрх, 201-дээш үхэртэй 5 өрх "Зээл хэрэгцээтэй" гэж хариулсан байна. Энэ нь цөөн тооны үхэртэй айлуудад зээлийн хэрэгцээ байгааг харуулж байна.

III.5.1.17 Мөн адуутай өрхүүдэд харьцуулан үзвэл: 10 хүртэл адуутай 325, 11-30 адуутай 172, 31-50 адуутай 52, 51-100 адуутай 18, 101-200 адуутай 9, 201-дээш адуутай 1 малчинд тус тус зээлийн хэрэгцээ байна. Цөөн тооны адуутай айлуудад зээлийн хэрэгцээ байна.

III.5.1.18 10 хүртэл тэмээтэй 216, 11-30 тэмээтэй 71, 31-50 тэмээтэй 22, 51-100 тэмээтэй 10, 101-200 тэмээтэй 8 малчдад зээлийн хэрэгцээ байна. Цөөн тооны тэмээтэй айлуудад зээлийн хэрэгцээ их байна.

III.5.1.19 10 хүртэл хоньтой 121, 11-30 хоньтой 124, 31-50 хоньтой 191, 51-100 хоньтой 160, 101-200 хоньтой 91, 201-500 хоньтой 33, 501-999 хоньтой 4, 1000-дээш хоньтой 4 малчдад зээлийн хэрэгцээ байна.

III.5.1.20 10 хүртэл ямаатай 86, 11-30 ямаатай 163, 31-50 ямаатай 198, 51-100 ямаатай 139, 101-200 ямаатай 104, 201-500 ямаатай 54, 501-999 ямаатай 7, 1000-дээш ямаатай 1 малчдад зээлийн хэрэгцээ байна.

III.5.1.21 ***Бод мал 30 хүртэл малтай өрхүүдэд, 30-аас 150 хүртэл бог малтай өрхүүдэд зээлийн хэрэгцээ байна. Цөөн малтай өрхүүд зээлийн баталгаа, барьцаа байхгүй тул зээл авах боломжгүй гэж үзэж байхад, олон малтай /50 ээс дээш бодтой эсвэл 150-аа дээш богтой өрхүүд/ зээл авах хэрэгцээ багатай байна.***

III.5.1.22 ***Малчид зээл, санхүүжилт-ын талаар хэрэгцээ байна гэж үзэх боловч зээлээ хэрхэн зарцуулах талаар мэдлэг чадвар бага, зээлийн баталгаатай барьцаат хөрөнгө үгүй байна. Нөгөө талаар арилжааны банкны зээлийн хүү өндөр байгаа нь малчдад зээл олгох зардал болон зээлийн эрсдэл өндөр байгаатай холбоотой байна.***

### III.5.2 Хөдөөгийн бичил санхүүгийн үйлчилгээ

III.5.2.1 Малчдад зориулсан зээлийн үйлчилгээний өнөөгийн байдлын талаар 2002.06 сард гаргасан НҮБХХ-ын "Бичил санхүүгийн судалгаа", 2003.07 сард хийсэн Кредит Монголын ХОНСҮХ төслийн тайланг зэрэг банк санхүүгийн зөвлөхүүдийн боловсруулсан материалууд дээр баримтын судалгаа хийлээ.

III.5.2.2 Малчдын дунд явуулсан анкетаар санал асуулга авах, ганцаарчилсан ба бүлгийн ярилцлага хийх, санал солилцох явцдаа Хаан банкны малчны зээл, ХАС банкны Малчны бүлгийн зээл, ХОНСҮХ төслийн зээл, Хоршоо, Компанийн бэлэн ба бэлэн бус зээл, ХЗХ-ны зээл, Барьцаалан зээлдүүлэх зээл /Ломбард/, Хувь хүний зээлийг малчдын хувьд давуу ба сул талыг харьцуулах маягаар судлав.

III.5.2.3 Малчдын зээлийн судалгааг, хоршоодод үнэлгээ хийсэн Өвөрхангай аймгийн Хархорин, Зүүнбаян Улаан, Төгрөг, Говь-Алтай аймгийн Дарви сумдын жишээн дээр хийв.

#### Хүснэгт 16 Өвөрхангай, Говь-Алтай аймгийн сумдын бичил санхүүгийн үйлчилгээний өнөөгийн байдал

Үзүүлэлт \ Сум	Зүүн баян Улаан сум	Төгрөг сум	Хар хорин сум	Дарви сум
<b>Санхүүгийн албан сектор</b>				
Банк	ХААН банк Монгол шуудан банк	ХААН банк -	ХААН банк Монгол шуудан банк	ХААН банк -
ББСБ	-	-	-	-
Хадгаламж зээлийн хоршоо	-	-	"Гүнж Хархорин" хоршоо "БЭХ" хоршоо	-
<b>Санхүүгийн албан бус сектор</b>				
Зээлийн үйлчилгээ үзүүлдэг Хоршоо, компани	-	-	-	1. "Буянт ундрал" компани 2. "Хужирт Жавхлант" хоршоо
Ломбард	-	-	1	-
Хувь хүн	2	Мэдээлэл байхгүй	Мэдээлэл байхгүй	Мэдээлэл байхгүй

III.5.2.4 Санхүүгийн албан секторт - сум орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Арилжааны Банкуудын суман дахь салбар, Банк Бус Санхүүгийн Байгууллага /ББСБ/ болон Хадгаламж Зээлийн Хоршоодыг .

III.5.2.5 Санхүүгийн албан бус секторт - мөнгөн ба мөнгөн бус зээлийн үйлчилгээг гишүүддээ үзүүлдэг хоршоо, компани ба зээл олгодог ломбард, хувь хүмүүсийг хамруулав.

III.5.2.6 Дээр сонгосон 4 сумдад ХААН Банкны салбар, Зүүнбаян-Улаан ба Хархорин суманд Монгол шуудан банкны салбар ажиллаж байна. Хархорин суманд 2 ХЗХ, 1 ломбард, Зүүнбаян-Улаан суманд 2 хувь хүн, Дарви суманд 2 аж ахуйн нэгж зээл олгодог байна. Хувиараа зээл олгодог хүмүүс сумдад байдаг боловч тэдний тухай албан ёсны мэдээлэл авах боломж хомс байлаа.

**Хүснэгт № 17.а** Сумдад олгосон зээл /2002 оны эцсийн байдлаар, мянган төгрөг/

Үзүүлэлт \ Сум	Зүүн баян Улаан сумын	Төгрөг сумын	Хар хорин сумын	Дарви Сумын
<b>Санхүүгийн албан сектор</b>				
ХААН банк	15,300.0	12,450.0	18,900.0	8,500.0
ХАС банк	2,300.0	5,150.0	-	-
Монгол шуудан банк	-	-	-	-
"Гүнж Хархорин" хоршоо	-	-	321.0	-
"БЭХ" хоршоо	-	-	73.7	-
<b>Санхүүгийн албан бус сектор</b>				
"Буянт ундрал" компани	-	-	-	21,700.0
"Хужирт Жавхлант" хоршоо	-	-	-	21,471.0
Ломбард	-	-	8,200.0	-
Хувь хүн	320.0	-	-	-

III.5.2.7 Өвөрхангай аймгийн Хархорин, Зүүнбаян Улаан, Төгрөг, Говь–Алтай аймгийн Дарви сумын хэмжээнд ХААН, ХАС, Монгол шуудан банкуудын зөвхөн "Малчны зээл"-ийг авч үзлээ. Бусад нэгжүүдийн хувьд бүх гаргасан зээлийн дүнг авав.

**Хүснэгт № 17.б**

Үзүүлэлт \ Сум	Зүүн баян Улаан сум	Төгрөг сум	Хар хорин сум	Дарви сум	Бүгд
Сумын хэмжээний малчны зээлийн хэрэгцээ /мян.₮/	<b>405 781,0</b>	<b>327,649.7</b>	<b>537 827,4</b>	<b>376,198.0</b>	<b>1,647,456.0</b>
Албан ба албан бус секторын олгосон зээл /мян.₮/	17,920.0	17600.0	27,494.7	51,671.0.0	<b>114,685.7</b>
Сумын хэмжээнд олгосон зээлийн эзлэх хувь	4%	5%	5%	8%	-
Үүнээс банкны зээл	17,600.0	17,600.0	18,900.0	8,500.0	<b>62,600.0</b>
Сумын доторхи зээл	320.0	-	8,594.7	43,171.0	<b>52,085.7.0</b>

III.5.2.8 Мал аж ахуй эрхлэгчдийн зээлийн нийт хэрэгцээний 4-8%-д зээлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

III.5.2.9 Зүүнбаян-Улаан суманд гарсан зээлийн 98%, Төгрөг сумын зээлийн 100%, Хархорин сумын зээлийн 69%, Дарви сумын зээлийн 16% нь тус тус арилжааны банкны зээл бөгөөд үүнд наад зах нь 2 сая төгрөг зээлийн хүү хэлбэрээр сумаас гадагш гарчээ.

III.5.2.10 Дээрх 4 сумын хэмжээнд малчны зээлийн хэрэгцээг арилжааны банкууд бүрэн хангана гэж үзвэл Зүүнбаян-Улаан сум 14.2 сая төгрөг, Төгрөг сум 11.5 сая төгрөг, Хархорин сум 18.8 сая төгрөг, Дарви сум 13.1 сая төгрөгийг тус тус хүүгийн төлбөрт төлөх бөгөөд суманд бий болсон ашиг орон нутгаас гарч байна.

III.5.2.11 ХААН Банк Малчны зээлийг 2001 оны 8 сараас эхлэн олгож байна. Малчны зээлийг хүйтний улиралд 350-иас дээш малтай, дулааны улиралд 150-иас дээш толгой малтай малчдад гэж улирлын байдлаар ялгавартай ханддагаас хүүхдийн сургалтын төлбөр, намрын хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороо дулаалах, өвлийн отор нүүдэл хийх зэрэг мал аж ахуйн үндсэн хэрэгцээнд болон цагаан сарын өмнөх санхүүгийн гол хүндрэлтэй үед зээл авах хязгаарлалтад ордог. Тухайн орон нутагт байгаль цаг уурын хүндрэл тохиолдсон үед малчны зээлийг зогсоодог байна.

III.5.2.12 Хавсралт № 2-д ХААН, ХАС Банкуудын “Малчны зээл” олгох шалгуурын харьцуулалт /№ 2.1/, Малчны зээлийн үндсэн нөхцөлүүд /№ 2.2/-г зэрэгцүүлэн харуулав.

III.5.2.13 ХААН банкны нийт зээлийн 8.7%-ийг малчны зээл эзэлж байна. /2003 оны 03 сарын байдлаар/

III.5.2.14 ХАС Банкны “Малчны бүлгийн зээл” нь ГС төслөөс сургалт зохион байгуулсан бүлгүүдээр хязгаарлагдаж байна. Бүлгийн зээлийг малчдын дунд хамтрах, хорших сургалтыг явуулах замаар, тэднийг мал аж ахуйгаа эрхлэхэд хамтран ажиллах үндсийг тавих бодлогын хүрээнд олгож байна. Зээл авсан малчны бүлгийн тоо 2002 онд 2 мянган төгрөг байсан бол 2003 онд 12 болж, 1 бүлэг дунджаар 3 сая төгрөгийн зээл авсан байна. Уг төслийн үргэлжлэх хугацаанаас ХАС-ын малчны бүлгийн зээлийн ирээдүй хамаарах магадлалтай.

III.5.2.15 Кредит Монгол ХХК-ийн ХОНСҮХ төслийн хүрээнд 2001-2003 онд туршилтын журмаар 3 сумын малчдад зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. 2003 оны 7 сард уг төслийн тайланг гаргаж хөдөөгийн сумдад бичил санхүүгийн үйлчилгээг хүргэх хувилбар түүн дотроо малчдын зээлийн асуудлаар тодорхой дүгнэлт зөвлөмжийг оруулсан байна.

III.5.2.16 Төслийн тайланд ганцаарчилсан байдлаар хувь хүн, аж ахуйн нэгжид олгодог бизнесийн, төлөвлөсөн хэрэглээний, шуурхай зээлийг өргөжүүлэх боломжтой гээд албан бус бүлгийн зээлийн хэлбэрийг олгоход сургалтад илүү их зардал шаардагдана гэжээ. Туршилт хийсэн сумдад бүлгийн гишүүдийнхээ өмнөөс барьцаа гаргах нь гол хүндрэлтэй асуудал болж үндсэндээ энэ зээлийн хэрэгцээ багассан гэж дүгнэжээ.

III.5.2.17 Сумын иргэд, малчдад зээл олгохдоо Зөвлөх Хороог сумдад байгуулж, түүний гишүүдээр 3 багийн засаг дарга, 2 иргэдийн төлөөлөгчийг сонгожээ. Зөвлөх Хороо зээл олгох шийдвэрийг гаргахгүй, зөвхөн зээлдэгчийн талаа мэдээлэл өгөх үүрэгтэй байна.

III.5.2.18 Кредит Монгол ХХК-ийн тайланд нийт зээлдэгчдийн 51% нь малчид байж, зээлийн зориулалтын 93%-ийг худалдаа, хөдөө аж ахуй-3%, модны үйлдвэрлэл-1%, үйлчилгээ -3%-ийг эзлэснийг харуулжээ.

III.5.2.19 ***ББСБ-аас сум орон нутагт үзүүлэх бичил зээлийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд ихээхэн хүч хөрөнгө гаргаж байгаа ч зээлдэгчид ямар бизнест зээлээ зориулж, зээлийн үйлчилгээний үр дүнд сумын эдийн засаг, зах зээлд ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг орхигдуулж байна.***

**III.5.2.20** Хүн ам цөөн бөгөөд сийрэг суурьшилтай, хэрэгцээт барааны тоо хэмжээ ба үйлдвэрлэлийн нөөц харьцангуй бага, сум, багт зээл авсан хүн бүр худалдааны бизнес эрхлэх шийдвэр гаргадаг болохыг дээрх тоо харуулж байна.

**III.5.2.21** **Хөдөөгийн сумдад зээлийг зах зээлийг дэмжих, зохицуулах бодлогогүйгээр өгөх нь**

- a. **Зээл авсан иргэд бүгд ижил төрлийн МГТЭ борлуулах, ХӨХБ нийлүүлэх үйл ажиллагаанд оролцож байна. Энэ байдал нь жижиглэнгийн чанартай болж үнэ буурах бус харин зардал, өртөгийг улам өсгөж байна.**
- b. **Зээл нь өөр төрлийн шинэ үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэхэд нөлөөлж чадахгүй байна.**

**III.5.2.22** Улаанбаатар хотод төвтэй Арилжааны банк, ББСБ-аас сум багт гаргаж байгаа бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд зээлийн зардал өндөр байх, зээлийн шинжилгээ, шийдвэрийг орон нутагт гаргах ба зээлд алсаас хяналт тавихад гол хүндрэл учирдаг. ХААН банк ба Кредит Монгол ББСБ-ын сумдын салбар өөрийн ажилтнуудыг бэлтгэж, зээлийн мэргэжилтэн, ня-бо гэсэн 2 орон тоотой ажиллаж байна. ХАС банк аймгийн төвийн салбартаа малчны бүлгийн зээлийн ажилтныг сургаж бэлтгэсэн байна.

**III.5.2.23** **Дээрх ББСБ-ын малчны зээлийн эргэн төлөлт 100% шахуу байгаа нь суманд банк, санхүүгийн ажилтан бэлтгэж, туршлагажуулах боломжтойг харуулж байна.**

**III.5.2.24** Кредит Монголын төслийн тайланд дурьдсанаар “Монголд малын хоргодол түгээмэл байдаг. Байгалийн хүндрэл болон малын өвчлөл богино хугацаанд их эрсдэл авчрахаас гадна хөгжлийн явцад сөрөг нөлөө бий болгодог” гээд, энэ нь Монголын банкны салбарынхан малчдад зээл олгохоос татгалзах хамгийн гол шалтгаан болдог гэж ДБ-ны Бодлого судлалын баримт бичигт дурьдсаныг тэмдэглэжээ.

**III.5.2.25** **Үүнээс дүгнэлт хийж үзэхэд ялангуяа хүнд хэцүүг давж туулахад нүүрээ буруулдаггүй санхүүгийн байнгын үйлчилгээ хөдөөгийн сумдад хэрэгтэй бөгөөд энэ үүргийг төвийн арилжааны банкууд биш сум орон нутгийн харьяалалтай санхүүгийн байгууллага л гүйцэтгэх боломжтой. Энэ бол Хадгаламж Зээлийн Хоршоо юм.**

**III.5.2.26** ХЗХ нь хүн ам төвлөрсөн сумын төвд зээл санхүүгийн хэрэгцээг даган үүсэх хандлага сүүлийн 2 жилд илүү түгээмэл болж байна. ХЗХ гишүүдийн идэвхи санаачлагаар, тэдний бага хэмжээний хувь нийлүүлсэн мөнгөн хуримтлал дээр дүрмийн сан бүрдүүлэн байгуулагддаг. Бэлэн мөнгө зээлийн хэрэгцээ төв, хөдөөд ялгаагүй их байдгаас зээл авах сонирхолтой гишүүдийн тоо түргэн өсч, хоршооны зээлийн эх үүсвэр хүрэлцэхгүй болдог байна. Үүнийг АХБ-ны ХОНСТ, ХААСХТөслүүдээр шийдвэрлэх боломжтой ч одоогоор энэ төслүүд нэр бүхий аймгуудад эхлэж байна.

**III.5.2.27** ХЗХороо гишүүддээ хадгаламж ба ХНХ-ийн хэмжээнд зээл олгодог бөгөөд зээлийн хэмжээ их болсон үед банкны адил барьцааны гэрээ байгуулж зээл гаргаж байна.

**III.5.2.28** **ХЗХ-ийн зээлийн хүүгийн хэмжээ нь арилжааны банкуудтай харьцуулахад өндөр боловч зээл авсан гишүүндээ хүүгийн тодорхой хэсэг нь**

---

**ногдол ашиг хэлбэрээр буцаж очдог (гишүүдийн мөнгөн орлого нэмэгдэнэ). Мөн ХЗХ-ийн орлогын татвар сумын орлогын татвар хэлбэрээр орон нутгийн эдийн засагт ордог.**

**III.5.2.29 Хадгаламж Зээлийн Хоршоо нь бизнесийнхээ утгаар жижиг банк болохоор дан ганц зээлийн үйлчилгээ эрхлэх нь мөн л зээлийн цаад үр дүнг төдийлөн сонирхохгүй байдалд хүргэж байна.**

III.5.2.30 Гишүүддээ хангамж борлуулалтын үйлчилгээ үзүүлдэг сумын хоршоо, компани гишүүн-малчдынхаа улирлын чанартай орлогод үндэслэн хэрэглээний бараа таваарыг зээлээр өгөх, шаардлагатай үед мөнгөн зээл олгох, түүхий эдийн бэлтгэлийн үед МГТЭ-ийг гишүүдээсээ дараа тооцоогоор авах зэргээр зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

**III.5.2.31 Зарим хангамж борлуулалтын хоршоо зээлийн үйлчилгээг хамтатган эрхлэснээр, сумын нийт өрхийг хамруулсан томоохон үйл ажиллагаа болон өргөжиж, гишүүдийн болон сумын нийгэм-эдийн засгийн хэрэгцээг хангах хэмжээнд амжилттай ажиллаж байна.**

III.5.2.32 Хөдөөгийн сумдад албан бүртгэлтэй ломбард байдаггүй боловч бие биенээ таних хүмүүсийн хүрээнд итгэлтэй хүндээ албан бус байдлаар өндөр хүүтэй зээл олгох явдал элбэг байна. /Хархорин 13 мянган хүнтэй томоохон суурин учир хөдөөний сумдаас онцлогтой байна./

**III.5.2.33 Ломбард болон хувь хүмүүсийн зээл нь барьцаа хөрөнгө л байвал, зээлийг шуурхай олгодог нь хэдийгээр хүү өндөр ч өдөр тутмын ба гэнэтийн санхүүгийн хэрэгцээг хангадаг гол арга хэвээр байна.**

III.5.2.34 Мал аж ахуй голлосон сумын эдийн засгийн өсөлтийг хангах ба жижиг зах зээлийг төлөвшүүлэхэд малчдын улирлын чанартай орлогод түшиглэсэн Хангамж борлуулалтын бизнесийг, Хадгаламж Зээлийн үйлчилгээгээр дэмжих нь мал аж ахуйд чиглэсэн, тохиромжтой хувилбар болж байна.

\* \* \*

## **Бүлэг IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **IV.1 Нэгдсэн дүгнэлт**

IV.1.1 Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ төсөл нь Монголын мал аж ахуй давамгайлсан сумдын малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгөтэй болгох, мөнгөн хуримтлал үүсгэх аргуудыг эрэлхийлсэн судалгааны төсөл юм.

IV.1.2 Төслийг НҮБ-ийн ХХ, МУ-ын Засгийн Газраас санаачлан 2002 оны 9 сард судалгааны ажлын багийг шалгаруулан 2003 оны 2 сараас 11 сар хүртэлх хугацаанд хэрэгжүүллээ.

IV.1.3 Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад хөдөлмөрөөр болон хөрөнгөөр хамтрах хорших аргууд түгээмэл болж, энэ нь өнөөгийн нөхцөлд харьцангуй дэвшилтэт арга болж байна.

IV.1.4 Хөдөлмөрөөр буюу үйл ажиллагаагаар хорших нь богино цаг хугацаанд нэгдмэл ажиллагааг (сааль, хадлан, отор нүүдэл гэх мэт) хийх давуу талтай боловч улирлын чанартай мал маллагааны ажлын онцлогоос шалтгаалан зохион байгуулалт болон эдийн засгийн хувьд тогтмол өгөөжтэй ажиллаж чадахгүй байна.

IV.1.5 Хөрөнгөөр хорших хэлбэрийн хувьд хуучин нэгдлийн суурин дээр үүссэн буюу хэт олон өрхийг хамруулсан хоршоодын үйл ажиллагаа нь гишүүддээ хүрч үйлчлэх, болон малчдын хүссэн ашгийг өгч чадахгүй байна. Чадварлаг цөөн гишүүдтэй зах зээлийн мэдлэг, харилцаанд тулгуурласан хөрөнгө болон хөдөлмөрөө хоршсон хамтын хэлбэрүүдийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжих хандлагатай байна.

IV.1.6 Эдгээр хорших хэлбэрүүдийг улам өргөжүүлэхийн зэрэгцээ хосломол байдлаар хэрэгжүүлэх нь орон нутгийн эдийн засагт төдийгүй малчид, энэ бизнесийг эрхлэгчдэд илүү өгөөжтэй юм. Тухайлбал, Малын гаралтай түүхий эдийн борлуулалт, хүнс өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийг хослуулан хийдэг хоршоог хадгаламж зээлийн үйл ажиллагааг зэрэгцүүлэн хийх байдлаар олон төрөлт хоршооны хэлбэрээр ажиллуулах нь тус хоршооны эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх нэг арга юм.

IV.1.7 Хөдөө орон нутагт ХААН Банк, ХАС Банк, Монгол Шуудан Банк болон ББСБ, ХЗХ-оод ажиллаж байна. Эдгээр байгууллагууд нь өөрсдийн бизнесийн зорилгыг нэгдүгээрт тавьж хэрэглэгчдээ буюу малчдыг эргэлтийн хөрөнгөтэй болгох, тэдний амьжиргааг дээшлүүлэх талаар бага анхаарч ажиллаж байна.

IV.1.8 Тухайлбал, Банкуудын хувьд суманд олгосон зээлийн хүүнээс олсон ашиг нь сум орон нутгийг хөгжүүлэх, хэрэглэгчдээ урамшуулах талаар зориулагдахгүй зөвхөн төв банкуугаа төвлөрүүлж байна. Энэ байдал нь хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хийхэд зардал болон эрсдэл ихтэй холбоотой. Гэвч зээлийн хүүгийн ашгийн тодорхой хувийг ашиг олсон сум орон нутагтаа зарцуулаад байвал эрсдэл буурахын зэрэгцээ малчид хөдөөгийн иргэд банкаар үйлчлүүлэх сонирхолтой болно.

IV.1.9 Малчдыг эдийн засгийн хувьд эргэлтийн хөрөнгөтэй болгоход санхүүгийн зах зээлийн хувьд I. Банкуудын зүгээс малчид, хөдөөгийн хэрэглэгч рүүгээ хандсан маркетингийг (хугацаандаа төлсөн зээлийг урамшуулах, байнгын зээлдэгчийг урамшуулах, орон нутгийн хөгжилд зарцуулах гэх мэт) хэрэгжүүлэх, II. Орон нутгийн иргэдийн үүсэл санаачлага дээр тулгуурласан Хадгаламж Зээлийн Хоршоог төрийн бодлогоор дэмжин өргөжүүлэх арга замууд байна.

IV.1.10 Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахын тулд дараахь арга хэмжээнүүдийг шат дараалан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

### **Зөвлөмж-1. Хөдөөгийн хөгжлийн стратегийн хувилбар**

IV.1.11 Орон нутгийн дэд бүтэц, зах зээлийн онцлогийг тусгасан “Орон нутгийн хөгжилд баримтлах стратегийн хувилбар”-уудыг боловсруулан санал болгож байна. Хөдөөгийн хөгжлийн талаар Эрчимжсэн, Бие даасан, Дэмжсэн хөгжлийн стратегийн хувилбаруудыг хэрэгжүүлэх, Үүний тул Монгол Улсын 329 сумыг дэд бүтэц, хүн ам зүй, экологи зэрэг хүчин зүйлээр судалж, тэдгээрийг бүлэглэн, сум бүрийн хөгжлийн стратегийн чиглэлийг тодорхойлж, тус бүрт нь чиглэсэн А. Мэдлэгжүүлэлт, В. Санхүүжилт, С. Үйлдвэржүүлэлтийг хийх эрх зүйн болон удирдлагын нөхцөлийг бүрдүүлэх.

IV.1.12 Манай орны хувьд орон нутгийн зах зээлийн эдийн засагт төрийн үүрэг оролцоо ямар байх талаар онол арга зүйн хувьд нэгдсэн ойлголт, төрийн бодлого шаардлагатай байна. Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогод орон нутгийн зах зээлийн бүтэц, түвшинг харгалзсан түүний удирдлага, эрх зүйн зохицуулалтыг хийх онол арга зүйн суурь судалгаа үгүйлэгдсээр байна. Энэ талаар цаашид судалгааг үргэлжлүүлэн хийх саналтай байна.

### **Зөвлөмж -2. Хоршоог дэмжин хөгжүүлэх талаар**

IV.1.13 Хоршоолох, хамтрах сонирхол хэрэгцээг нь улам хөгжүүлэн иргэдийн болон удирдлагын зүгээс идэвхи санаачлага бий болсон орон нутгийн өөрсдийн захиалгаар сумдад Олон талт хоршоог байгуулах (Хангамж борлуулалт, Хадгаламж Зээлийн Хоршоо) үе шаттай мэдлэгжүүлэлт, санхүүжилтийг хийж, мэргэжсэн, дадлагдсан зөвлөхөөр хангах тухай зөвлөмжийг боловсруулж дэвшүүлж байна. Үүнийг цаашид хэрэгжүүлэх дэд төслийн санааг боловсруулаад байгаа бөгөөд энэ талаар ажиллах мэргэжлийн баг бүрдүүлсэн болно.

IV.1.14 Одоогоор ажиллаж байгаа хоршоод болон хамтран ажиллаж байгаа бусад хэлбэрүүдийн давуу тал, ололт амжилтыг судлан бусдад түгээх, сул ажилласан нэгжүүдийн алдсан шалтгааныг шинжлэн бусад хоршоод алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Хоршооны үйл ажиллагаа эрхлэх, төсөл тооцоо хийх, удирдах талаар сэдэвчилсэн, шаталсан сургалтуудыг явуулах.

### **Зөвлөмж 3, 4. Сургалтын агуулга, хэрэгжүүлэх арга**

IV.1.15 Зөвлөмж 1, 2-ийг хэрэгжүүлэхийн тулд Малчид төдийгүй мал аж ахуйн бизнес эрхлэгчид, орон нутгийн төрийн удирдах ажилтнуудыг ажил мэргэжлийн түвшин бүрд нь тохирсон шаталсан зах зээлийн эдийн засгийн суурь мэдлэг эзэмшүүлэх Мэдлэгжүүлэх нь нэн түрүүн хийх зорилтот ажил юм. Эдийн засгийн боловсрол, мэдлэгийг сум орон нутгийн жишээн дээр, бодит амьдралын загвар дээр хийх нь үр дүнтэй юм.

IV.1.16 Мал аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалт, нийлүүлэлт, санхүү, даатгалын дэд системүүдийн харилцан нөхцөлдөх, сум орон нутагтаа үр өгөөжтэй, малчиддаа ашигтай зах зээлийн оновчтой харилцааг бий болгохын тулд судалгааг эконометр, экономиксийн онол арга зүйн түвшинд цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатай байна. Сум нь харьцангуйгаар хагас хаалттай систем болохынхоо хувьд эдийн засгийн загварчлалаар тодорхойлогдож, хэрэгжүүлэхэд эрх зүйн талаасаа хүн ам цөөн нь хяналтын тогтолцоог бүрдүүлэх давуу талтай юм.

Энэ судалгааны ажил Монгол Улсын бүсчилсэн хөгжлийг үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга зүйг баяжуулсан санааг агуулахын зэрэгцээ цаашид бүсчилсэн хөгжлийн суурь судалгаатай уялдуулсан судлах шаардлага байгаа болно.



#### **IV.1.18 Малчдын хоршооны ажиллагааг боловсронгуй болгох талаарх дэд дүгнэлт**

1. Суманд мал маллагааны /хадлан тэжээл авах, оторт явах/ зэргээр хөдөлмөрөө хоршин ажиллаж ирсэн туршлага байгаа ч хөрөнгөөр /малаар/ хорших талаар болгоомжилсон, хүлээсэн байр суурьтай байна.
2. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ хамтран борлуулах талаар хорших сонирхол их /32,5%/ байгаа ч энэ нь улирлын чанартай, мөн "зээл"-ийн сэтгэлгээ нь хоршоогоо эргэлтийн мөнгөгүй байдалд оруулж байна.
3. Малчид хоршин хамтран ажиллах хэрэгцээгээ улам бүр мэдэрч байгаа ч төдийлөн амжилт олж чадахгүй байгаа нь
  - Малчдын эдийн засгийн боловсрол,
  - Малчид өмчийн харилцаанд оролцохоос болгоомжилж байгаа,
  - Хоршин хамтрахад нь эрх зүйн болон удирдлагын арга ажиллагаа дутагдаж байгаатай холбоотой.
4. Хоршооны өнөөгийн дүр төрх хуучин нэгдэл, худалдаа бэлтгэлийн ангийн суурин дээр үүсэн байгуулагдсан хоршоодод менежмент, маркетинги, санхүүгийн судалгааг хийж, өөрчлөн шинэчлэх эсвэл тухайн хоршоог татан буулгаж сумдад шинэ хоршоо үүсэх нөхцөлийг бүрдүүлэх нь хойшлуулашгүй асуудал болж байна. Энэ ажлыг шуурхай эхлэхгүй бол хөдөөгийн иргэд малчдын хоршоонд итгэх итгэлд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.
5. МГТЭ-ийн нийлүүлэлт, тоо хэмжээний хувьд буурч байгаа нь гишүүдэд хоршооноос гадуур түүхий эдээ илүү үнэ хүргэж борлуулдаг өөр суваг байгааг харуулж байна. Мөн гишүүдийн нийлүүлж байгаа МГТЭ-ийн нэр төрөл цөөн байна.
6. Үйл ажиллагаа нь тогтворжсон хоршоодын маркетингийн онцлогыг тодорхойлж (гишүүдийн эдийн засгийн сонирхлыг хослуулах, нэг малаас авах түүхий эд ба ашиг шимийг нэмэгдүүлэх, гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх, борлуулалт нийлүүлэлтийн сувгаа сонгох гэх мэт), маркетингийн стратеги боловсруулах шаардлага тулгарч байна. Сумын нийгэм, эдийн засагт хоршооны үйл ажиллагааны төрөл, хэмжээ ихээхэн нөлөөтэй байна.

#### **IV.1.19 Сумын санхүүгийн зах зээлийн талаархи дэд дүгнэлт**

1. Малчдын орлого бага, бэлэн мөнгөний хуримтлал байхгүйгээс байгаль, цаг агаарын хүндрэл бэрхшээл тохиолдох үед, бусдын гар харах, бүх зүйлийг гадны тусламж, дэмжлэгээр шийдвэрлэх шаардлага тулгарч байна.
2. Сумын иргэдийн гар дээрх бэлэн мөнгөний нөөц хомс байгаа нь суманд шинэ нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ нээгдэх, хөгжих нөхцөл боломжийг багасгаж байна.
3. Малчин өрхийн аж ахуй амиа аргацаасан хэлбэртэй байгаас шалтгаалж, ихэнхи ядуувтар болон дунд чинээний өрхүүдэд мөнгөн хуримтлал үүсэлгүй, харинч цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц хорогдох, улмаар амьжиргааны түвшин байнга буурах хандлагатай байна.
4. Сумдад, ялангуяа хүн ам төвлөрсөн суманд зээлийн хэрэгцээ их байдгаас хоршооны үйл ажиллагаа түргэн өргөжиж, гишүүнчлэлийн хүрээ хурдан өсөж байгаа бөгөөд цаашид зээлийн багцийн хэмжээг гадны эх үүсвэрээр нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

5. Сум орон нутагт зээл санхүүгийн хэрэгцээ их байгаа ч түүний нийлүүлэлт хүрэлцээ бага, арилжааны цөөн банкнаас гаргаж байгаа зээлийн бүтээгдэхүүн малчдад бүрэн хүрэхгүй, малчдын бодит шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байна.
6. Малчдын зах зээл, эдийн засгийн мэдлэг, чадвар бага байна. Малын тооноос чанарыг эрхэмлэх, шаардлагатай үед эдийн засгийн ухаанаар мал сүргээ бүтэц тооны өөрчлөлт хийх зэрэг байгаль цаг уур болон зах зээлийн нөхцөлд тохируулан илүү ашиг орлого олж амьдрах ёстой гэсэн ойлголт суугаагүй, түүнд суралцах идэвхи санаачлага малчдад хангалтгүй, зарим нэг санаачлага гаргаж байгаа нь арга барилаа олохгүй байна.
7. Арилжааны банкны үйл ажиллагаа нь малчдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилийн цикл, шаардлагатай үед үүссэн зээл санхүүгийн хэрэгцээтэй тохирохгүй байна. Мал аж ахуйн улирлын чанартай борлуулалтын орлого, МГТЭ-ийн үнийн хэлбэлзэл болон сумын зах зээлийн онцлогоос шалтгаалан хөдөөд хүргэх бичил санхүүгийн үйлчилгээг сум орон нутаг өөрсдөө /дотроо/ зохион байгуулах нь илүү зохимжтой.
8. Орон нутгийн бус Банк Санхүүгийн Байгууллагаас авсан зээлийн хүүгийн ашиг болон тэдгээр байгууллагын орлогын албан татвар суманд үлдэхгүй байгаа нь орон нутагт мөнгөн хуримтлал үүсэх боломжийг багасгаж байна.

#### **IV.1.20 Сумын бараа бүтээгдэхүүний зах зээлийн талаарх дэд дүгнэлт**

1. Сумын бичил зах зээлийн судалгаа загвар төдийлөн хийгдээгүй, орон нутгийн төрийн байгууллагаас зохицуулалт зохион байгуулалтгүй урсгалаараа явагдаж байгаагаас МГТЭ-ийн үнэ буурах, ХӨХБ-ны нийлүүлэлт тасалдах, малчдын хөрөнгийн эргэлт удаашрах улмаар малчид болон орон нутгийн эдийн засагт ашиг оруулж чадахгүй байна.
2. МГТЭ-ийн борлуулалт, ХӨХБ-ны хангамжийг хийж байгаа өнөөгийн суваг малчдын орлого бага байх нэг шалтгаан болж байна.
3. Зах зээлийн нөхцөлд аж ахуйгаа тооцоотой хөтлөх, хамтын бизнес эрхлэх, аж ахуйгаа санхүүгийн мэдлэгтэй хөтлөн эрхлэхэд малчдад орон нутагт нь шууд амьдралтай нь холбосон үе шаттай сургалт дутагдаж байна.

## IV.2 Бодлогын зөвлөмж

### IV.2.1 Сумын эдийн засгийг хөгжүүлэх стратегийн хувилбарууд (Хөгжлийн загварчлал)

*Засгийн газар, Хандивлагчид, Яамдын бодлого  
боловсруулагчдад зориулсан зөвлөмж*

#### Үндэслэл

IV.2.1.1 “Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ”-ний үр дүнд Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь зөвхөн малчид, мал аж ахуй давамгайлсан сумдын удирдлагын ажил төдийгүй үүнд төрийн бодлого зохицуулалт шаардлагатай байна гэж дүгнэж Бүсчилсэн хөгжлийн хөдөөгийн нийгэм эдийн засгийн талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаанд түлхэц болох нэгэн аргын замыг боловсруулан дэвшүүлж байна.

#### Арга зүйн үндэс

IV.2.1.2 Хөдөөгийн сумдыг бүсчлэн хөгжүүлэхдээ сумдын хүн ам зүй, экологи, дэд бүтэц зэргийг харгалзан хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх хувилбаруудыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал, Сумдыг эрчимжүүлэн хөгжүүлэх, Бие даан хөгжүүлэх, Дэмжин туслах хөгжүүлэх нь нэгэн багц арга юм.

IV.2.1.3 **Эрчимжүүлэн хөгжүүлэх** нь дэд бүтэц сайн хөгжсөн, төвлөрсөн зах зээл орчимд байрлах хот суурин газрыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр эрчимжсэн мал аж ахуйг эрчимжсэн газар тариалантай хослуулан хөгжүүлэх суурин аж ахуй /ферм/-г технологийн өөрчлөлт дэвшилттэй уялдуулан хэрэгжүүлэх хөгжлийн хувилбар юм.

IV.2.1.4 Энэ хөгжлийн хувилбарыг хэрэгжүүлэхдээ төрөөс зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжсэн, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх чиглэлийг баримтална. Үүний тул жижиг бизнес эрхлэгчдийг эхний 1-5 жилд хөнгөлттэй зээл, татварын хөнгөлөлт, үнийн уян хатан бодлого зохицуулалтыг үе шаттайгаар хийж, жижиг бизнес хөгжих нөхцөл бололцоог нь дэмжин хэрэгжүүлнэ.

IV.2.1.5 Хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл нь жижиг дунд үйлдвэр, фермийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

IV.2.1.6 **Бие даан хөгжүүлэх** хувилбарт дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн, төсвийн орлого, зарлагад алдагдал ихтэй хөдөөгийн сумдыг хамруулна. Энд хагас суурин мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.

IV.2.1.7 Нутгийн удирдлагыг эдийн засгийн хувьд бие даан ажиллах эрх зүйн зохицуулалтыг төрийн бодлогын түвшинд шийдвэрлэж, сумын ажиллах хүчнийг мэдлэгжүүлэн нөөцийг бүрдүүлж, иргэдийн эдийн засгийн сонирхол хэрэгцээнд тулгуурласан бодлого баримтална. Үүний дүнд хөдөөгийн сумаас төвлөрсөн зах зээл рүү чиглэсэн, хангамж боруулалтын үр ашигтай бизнес эрхлэх нөхцөл бүрдэнэ.

IV.2.1.8 Энэ хөгжлийн хувилбарыг хэрэгжүүлэхдээ орон нутгын зах зээлийн дотоод өрсөлдөөнийг дэмжсэн, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх чиглэлийг баримтална. Үүний тул жижиг бизнес эрхлэгчдийг эхний 1-5 жилд хөнгөлттэй зээл,

татварын хөнгөлөлт, үнийн уян хатан бодлого зохицуулалтыг үе шаттайгаар хийж, жижиг бизнес хөгжих нөхцөл бололцоог нь дэмжин хэрэгжүүлнэ.

IV.2.1.9 Хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл нь жижиг дунд үйлдвэр, фермийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

**Хүснэгт № 18** Сумыг хөгжүүлэхэд баримтлах стратегийн хувилбар

Үзүүлэлт	Хөгжлийн хувилбарууд		
	Эрчимжүүлэн хөгжүүлэх	Бие даан хөгжүүлэх	Дэмжин туслах
Дэд бүтэц	Сайн	Харьцангуй сул	
Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэв шинж	Эрчимжсэн мал аж ахуй, эрчимжсэн газар тариалан хосолсон суурин а.а /ферм/	Хагас суурин мал аж ахуй, газар тариалан	Бэлчээрийн мал аж ахуйн
Байршил	Төвлөрсөн зах зээлийн орчимд	Төвлөрсөн зах зээлээс харьцангуй алслагдсан	
Төсвийн орлого, зардал	Орон нутгийн эдийн засагт орлого оруулна		Улсын төсвөөс татаас өгөх
Хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн чиглэл	Жижиг дунд үйлдвэр, фермийг хөгжүүлэх		Ядуурлыг бууруулах /ӨАЧДХөт/
Зах зээлийн зохицуулалтын арга	Зах зээлийн чөлөөт өрсөлдөөн	Төрийн зохицуулалттай сумын дотоод өрсөлдөөн	

*"Төвлөрсөн зах зээл" гэдэгт - хот, аймаг болон хилийн боомтыг хамруулна.*

IV.2.1.10 Энэ стратегийг хэрэгжүүлэхдээ бүсчилсэн хөгжилтэй уялдуулахын зэрэгцээ тодорхой сумдыг туршилт "Удирдлагын гэрээ"-гээр баг бүрдүүлэн ажиллуулна. Үүний үр дүнд төсвийн алдагдал буурахын зэрэгцээ иргэдийнх нь сонирхол хэрэгцээнд нийцүүлэн хөдөөгийн сумын зах зээлийг удирдах арга туршлага бий болно.

IV.2.1.11 Дэмжин туслах хувилбарт дэд бүтэц харьцангуй сул, төвлөрсөн зах зээлээс алслагдсан сумыг хамруулна. Энэ нутагт бэлчээрийн мал аж ахуйг эрхэлнэ. Энэ хувилбарт хамрагдсан суманд өрхийн амьжиргааг дээшлүүлэх замаар ядуурлыг бууруулах, иргэдийн боловсрол, эрүүл мэндэд илүү анхаарна.

IV.2.1.12 Нутгийн удирдлагыг дэмжсэн, ажиллах хүчний нөөцөөр хангах эрх зүйн зохицуулалтыг төрийн бодлогын түвшинд шийдвэрлэхийн зэрэгцээ сумын ажиллах хүчний өөрийн нөөцийг мэдлэгжүүлэх, иргэдийн язгуур сонирхолд тулгуурласан

бодлого баримтална. Хөдөөгийн иргэд, малчдын хүнс өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээг төрийн зохицуулалт, дэмжлэгтэйгээр бий болгоно. Бөөний худалдааны сүлжээг эрхлэх аж ахуйн нэгжүүдэд татварын болон бусад хөнгөлөлтийг төрөөс үзүүлж болно.

IV.2.1.13 Хөдөөгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх хувилбар нь **Дэмжин туслах** хувилбараас **Бие даан хөгжих**, цаашид **Эрчимжүүлэн хөгжүүлэх** хувилбарт шилжин хөгжих зарчмыг баримтална. Хөгжлийн хувилбаруудыг хэрэгжүүлэхдээ сонголтын үе буюу суурь судалгаа, бэлтгэл үе, хөгжлийн үе шат ахих гэсэн дэд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

### **Жишээ**

IV.2.1.14 Өвөрхангай аймгийн 19 сумдаас Хархорин, Зүүнбаян Улаан, Төгрөг сумдыг харьцуулан судалж үзлээ. Нэг аймгийн гурван сум боловч экологи, хүн ам зүй, дэд бүтэц, мал сүргийн бүтцээр харилцан адилгүй байна.

IV.2.1.15 Эрчимжүүлэн хөгжүүлэх сум. Хархорин сум нь хангайн бүсэд орших 13500 хүн амтай, хүн амын нягтшил 5.7, газар тариалан эрхлэх бүрэн боломжтой, мал сүргийн 50 гаруй хувь хонин сүрэг, 1995-96 онуудад төсвийн орлого зарлага нь балансалж байсан, зах зээлийн орчин бүрдэж байгаа. Энэ сумыг Эрчимжүүлэн хөгжүүлэхэд хүний болон байгалийн нөөц, дэд бүтцийн бүрэн боломжтой юм.

IV.2.1.16 Бие даан хөгжүүлэх сум. Зүүнбаян-Улаан сум нь хойд хэсгээрээ хангайн бүсэд, урьд хэсгээрээ хээрийн бүсэд оршиж, 4600 хүн амтай, хүн амын нягтшил 1.9, хөдөө аж ахуйн эдэлбэр, бэлчээрийн нөөцтэй, мал сүргийн 50 гаруй хувь нь хонин сүрэг, байгалийн нөөц баялаг ихтэй. Аймгийн төв болон УБ хот уруу шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд их болсон, дэд бүтэц сайн, зах зээлийн орчин бүрдээгүй, сургууль завсардалт ихтэй. Энэ сумыг эдийн засгийн хувьд Бие даан хөгжүүлж, төсвийн алдагдалгүй ажиллуулах боломжтой.

IV.2.1.17 Дэмжин туслах сум. Төгрөг сум нь говийн бүсэд орших бөгөөд 2800 гаруй хүн амтай, хүн амын нягтшил 0.5, нэг өрхөд ногдох хүний тоо 4.4, мал сүргийн 55 гаруй хувь нь ямаан сүрэг, төвлөрсөн зах зээлээс алслагдсан, татвар төлөх аж ахуйн нэгж 2, төсвийн зарлагад орлогын эзлэх хувь 2002 оны байдлаар 16,2%, мал сүргийн тоо сүүлийн жилүүдэд буурч, хүн амын шилжих хөдөлгөөн ихсэх хандлагатай.

IV.2.1.18 Мэргэжилтэй ажиллах хүчний дутагдалтай. Цахилгааны эх үүсвэр/104/-тэй болон телевиз/63/-тэй өрхийн тоо нь бусад сумдаас харьцангуй доогуур байна. Энэ сумыг Дэмжин тусалж мэргэжилтэй ажиллах хүчин, удирдлагаар хангах, хүнийг хөгжүүлэх, бөөний худалдааны сүлжээг байгуулах зэргээр төрөөс зохицуулалт хийж байгааг улам идэвхижүүлэх нь оновчтой юм.

IV.2.1.19 Хавсралт № 3-д Өвөрхангай аймгийн Хархорин, Зүүнбаян-Улаан, Төгрөг сумдын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд-ийг харьцуулан харуулав.

\* \* \*

## **IV.2.2 Хангамж борлуулалт, Хадгаламж Зээлийн үйлчилгээг өргөжүүлэх талаар**

IV.2.2.1 Малчдын хоршоолох, хамтрах сонирхол хэрэгцээг нь улам хөгжүүлэн иргэдийн болон удирдлагын зүгээс идэвхи санаачлага бий болсон /сумын захиалгаар/ сумдад Олон талт хоршоог байгуулах /Хангамж борлуулалт, Хадгаламж Зээлийн Хоршоо/ үе шаттай мэдлэгжүүлэлт, санхүүжилтийг хийж, мэргэжсэн, дадлагдажсан зөвлөхөөр хангах тухай зөвлөмж.

IV.2.2.2 Мал аж ахуй голлосон хөдөөгийн сумдад нийтлэг байх, сумын нийгэм-эдийн засагт нөлөө үзүүлж, сумын зах зээлийг төлөвшүүлэхэд Хангамж Борлуулалт, Хадгаламж Зээл /ХБ-ХЗ/-ийн олон төрөлт хоршоог хөгжүүлэх нь зүйтэй байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд:

- Хангамж Борлуулалтын сүлжээг сумаас санаачлан зохион байгуулах нь МУ-ын ЗГ-аас Бөөний худалдааны сүлжээг орон нутагт байгуулах хөтөлбөрийн нэг хувилбар дэд хэсэг гэж үзэж, түүнийг турших, дэлгэрүүлэх сургалт зохион байгуулах,
- Төвлөрсөн зах зээл дээр "Сумын нэрийн худалдааны" төвийг байгуулах (цаашид МГТЭ-ийн худалдааны бирж болж хөгжих)-д газрын зөвшөөрөл олгох, агуулахын барилга байгууламж,
- Хангамж Борлуулалтын сүлжээг бий болгоход Хадгаламж Зээлийн үйлчилгээг хөшүүрэг болгон ашиглах, хадгаламж зээлийн үйлчилгээг бөөний зээлээр дэмжих,
- Сум дундын ББСБ байгуулах төсөл боловсруулж хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр олох,
- ХБ-ХЗ-ийн олон төрөлт хоршооны загварыг боловсруулж, хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх бодлого, үйл ажиллагааг дэмжсэнээр

малчид ба төвлөрсөн зах зээлийг холбосон бүтээгдэхүүн борлуулалтын бөөний худалдааны сүлжээг сум орон нутгаас санаачлан, орон нутгийн иргэд өөрсдөө зохион байгуулах нь малчдын болон орон нутгийн эдийн засагт илүү үр өгөөжтэй юм.

IV.2.2.3 Сумын газар зүй, байршил, байгаль цаг уур, малын төрөл бүтэц, аж ахуй эрхэлж ирсэн уламжлалт арга, иргэдийн амьжиргааны түвшин, хөдөлмөрч чанар зэрэг онцлогоос шалтгаалан сум бүр өвөрмөц байх боловч мал аж ахуй голлосон хөдөөгийн 308 сумдын<sup>4</sup> хувьд нийтлэг байх хоршооны хэлбэр бол МГТЭ-ийн борлуулалт ХӨХБ-ны хангамжийн бизнес бөгөөд үүнийг хадгаламж зээлийн үйлчилгээтэй хослуулах нь хамгийн тохиромжтой хувилбар болж байна.

Хангамж Борлуулалт, Хадгаламж Зээлийн үйлчилгээг зэрэгцүүлэн эрхлэх нь олон талын давуу талтай юм. Үүнд:

### **IV.2.2.4 Малчдын хувьд**

1. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлийн хамгийн өндөр үнэ ханшаар төвлөрсөн зах зээлд борлуулах,
2. Хүнс, өргөн хэрэглээний бараагаа төвлөрсөн зах зээлээс бөөнөөр худалдан авч баталгаатай барааг гишүүддээ боломжийн үнээр нийлүүлэх,
3. Хөрөнгө /түүхий эд, мал, мөнгө, үнэт зүйлс, баталгаат, барьцаат хөрөнгө/ байршуулсан гишүүд нь хөрөнгөө хадгаламж хэлбэрээр оруулж, хүүний орлого авах,

<sup>4</sup> МУ-ын хэмжээнд 329 сумаас

4. Хөрөнгө /ахуйн болон мал маллагааны зориулалтаар/ шаардлагатай гишүүд нь хоршооноос зээл авч, хоршоондоо ашиг бий болгох,
5. Нийт гишүүд хоршооны үйл ажиллагааны ашгаас ноогдол ашиг авах,
6. Хоршоо нь мал маллагааны хадлан тэжээл бэлтгэх, мал эмнэлэг, отор, туувар зэрэг үйл ажиллагааг эрхэлж болно.
7. Хүн хүчээ хуваарилах шаардлагатай бол мэргэжилтэн болон ажиллах хүч нэмж ажиллуулах боломжтой,
8. Гишүүддээ сургалт явуулах, удирдах ажилтнаа бэлтгэх боломжтой,
9. Хоршооны гишүүд бие биеэ таних тул зээлийн хэмжээ, баталгааны талаар эрсдэл болон зардал гарахгүй, иймээс хүүгийн хувь бага байна.
10. Бөөний худалдааны сүлжээг сумаас санаачлан зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэнээр МГТЭ ба ХӨХБ-ны борлуулалтаас олох худалдааны ашгийг малчид өөрсдөө авна
11. Бөөний ба жижиглэнгийн үнийн тухай ойлголтыг сумын иргэдэд өгч, малын гаралтай түүхий эдээ нийлүүлэн, тоо хэмжээг нэмэгдүүлж, өндөр үнэ хүргэж борлуулах ба хүнс, өргөн хэрэглээний барааг их хэмжээгээр, бөөний үнээр авах замаар өрхийн өнөөдрийн орлого нэмэгдэнэ.

#### **IV.2.2.5 Сумын хувьд**

1. Шүүд үр дүн: Хоршооны үйл ажиллагаа өргөжснөөр малчдын амьжиргаа /эдийн засаг, нийгмийн асуудал/ шийдэгдэх алхам болно.
2. Дүнд хугацааны үр дүн: Сумын төсөвт орлого орох боломж бүрдэнэ. Орон нутгийн эргэлтийн хөрөнгө нэмэгдэнэ.
3. Урт хугацааны үр дүн: Хоршооны үйл ажиллагаа өргөжин, үйлдвэрлэл, ажил эрхлэлт сайжирна. Хоршоод нэгдэх, төрөлжих үйл явц үргэлжилж, хоршоог удирдан ажиллуулах ур ухааны сан бий болно.
4. Хадгаламж Зээлийн Хоршооны орлогын албан татвар орон нутагтаа орно.
5. Хөдөөгийн санхүүгийн чадавхи сайжирч бэлэн мөнгөний хуримтлал үүсэж өөрийн мөнгөтэй болох ба дараагийн шатанд Хадгаламж Зээлийн үйл ажиллагааг Хангамж Борлуулалтын үйл ажиллагаатай хослуулан хөгжүүлснээр Сумын барааны болон санхүүгийн зах зээл төлөвших нөхцөл бүрдэнэ.

#### **IV.2.2.6 Хоршооны үйл ажиллагааны эдийн засгийн хөшүүрэг**

1. Хүнс, өргөн хэрэглээний бараа таваарыг зөвхөн бэлэн мөнгөөр худалдан авах,
2. Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ чанарын хувьд анхаарч, харилцан хүлээлцэх,
3. Бүтээгдэхүүнийг борлуулах үнэ болон хугацааны саналаа бичгээр хийх,
4. Зээл авсан гишүүд зээлийн гэрээгээ баримтлах,
5. Мэдлэгжүүлэлтийг санхүүжилтын адил түвшинд үзэх.
6. Хоршоонд хөрөнгө байршуулахдаа мөнгөн хэлбэрээр нийлүүлэх, ашгийн хувийн зэргийг хоршооны дүрмэндээ заасан байна.

**IV.2.2.7 Хадгаламж борлуулалт, хадгаламж зээлийн үйл ажиллагааг хөгжүүлэхдээ даатгалын үйлчилгээтэй холбох ёстой бөгөөд үүнийг шийдэрлэх асуудлыг нэн даруй судалж боловсруулах шаардлагатай байна.**


## IV.3 Хэрэгжүүлэх зөвлөмж

### IV.3.1 Малчдын сургалтын хэрэгцээг нарийвчлан тогтоож, сургалт зохион байгуулах

*Сум, Баг, Малчдад зориулсан зөвлөмж*

IV.3.1.1 Малчдын 90 гаруй хувь малчдад хэрэгтэй сургалтанд хамрагдах, суралцах сонирхолтой байгаа нь малчид мэдлэг боловсролыг эрхэмлэн, мал маллахын зэрэгцээ сурах мэдэх хэрэгцээ байгааг харуулж байна.

IV.3.1.2 Мал маллахын зэрэгцээ орлого олох өөр арга зам, хоршооны сургалтыг ихэд сонирхож байна. Өнөөдөр энэ талаархи сургалт, мэдээлэл үгүйлэгдэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Үүний зэрэгцээ малчид ямар нэгэн үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэл эрхэлхэд эрх зүйн мэдлэг дутагдаж байна гэж үзэж байна.



IV.3.1.3 Мөн зээл авах, түүнд шаардагдах баримт бичгийн талаар мэдлэгтэй болох хэрэгцээ шаардлага малчдад их байна.

IV.3.1.4 *Та ямар сургалтанд хамрагдах сонирхолтой байна вэ?* гэсэн асуултанд малчдын 40,8% нь малчны орлого, зарлагыг тодорхойлох, малчны төсөв зохиох сургалтыг сонирхон цаашид сургалт судалгаандаа анхаарч ажиллахыг хүсч байв. Бусад сэдвийг харьцангуй бага сонирхож байгаа ч эдгээр сэдвүүдийн агуулгыг задалж нарийвчлан судлах шаардлагатай нь судалгааны явцад ажиглагдлаа.

IV.3.1.5 8-р анги төгссөн 114 малчин хоршооны тухай сургалтанд, 127 малчин мал маллахын зэрэгцээ орлого олох өөр арга замын тухай сургалтанд хамрагдана гэж хариулсан нь хамгийн өндөр хариулт болжээ. 8-р анга төгссөн боловсролтой малчид сурах сонирхол их байгааг цаашид нарийвчлан сургалтын агуулга, хөтөлбөр тусгах нь зүйтэй юм.



IV.3.1.6 Дээд боловсролтой малчдын 30% хоршооны тухай, 25% мал маллахын зэрэгцээ орлого олох өөр арга зам сэдэвт сургалтыг түлхүү сонирхож байна.

IV.3.1.7 Сургалтын агуулгыг малчдын настай харьцуулан судалж, үнэлсэн бөгөөд үүнд их ялгаа гараагүй бөгөөд суралцах сэдэв, агуулга, хэлбэрийг боловсролын түвшинтэй харгалзсан сургалтын хөтөлбөр, гарын авлага гаргах нь зүйтэй юм.

IV.3.1.8 Малчид зах зээлийн эдийн засгийн талаар мэдэх, мэдээллийн хэрэгцээ их байна. Малчдад зориулсан системтэй мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх сургалт явагдаагүй байна.

#### **IV.3.1.9 Малчдын эдийн засгийн боловсролд**

1. Малчин өрхийн орлого, зарлага тооцох аргачлал, өрхийн төсөв
2. Зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах арга ажиллагаа, зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүтээгдэхүүний чанар.
3. Хоршин хамтарч ажиллах хамтын оролцооны удирдлагын үндэс, арга ажиллагааны онцлог /хот айл, бүлэг/
4. Зээлийн ашиглалтын талаарх мэдлэг чадвар эзэмшүүлэх сургалт
5. Малчин өрхийн мал сүргийн зохистой бүтэц бий болгох арга ажиллагаа

IV.3.1.10 Сэдэвт сургалтуудыг Удирдлагын Академи, ХААИС, СЭЗДС, ХҮДС-ийн судлаач эрдэмтэдийн зөвлөгөө, орон нутгийн нөөц боломжиндоо тулгуурлан явуулах шаардлагатай байна.

### **IV.3.2 Сум, багийн удирдах ажилтнуудад эдийн засгийн мэдлэг олгох сургалтын агуулга**

IV.3.2.1 Малчдын хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь малчдын амьжиргаанд төдийгүй сум орон нутгийн хөгжлийн дотоод эх үүсвэр юм. Энэ талаар орон нутгийн удирдлагууд ч санаа тавьж, орон нутгаа зах зээлийн харилцаанд нийцүүлэн удирдах гэхээсээ илүү төсвийн санхүүжилт, тогтоол шийдвэр харсан үрэлгэн сэтгэлгээнээсээ гараагүй байна. Энэ сэтгэлгээг өөрчлөх, эдийн засгийн суурь болон практик мэдлэг, чадвар эзэмшүүлэх шаардлагатай байна.

IV.3.2.2 Сум, багийн удирдах ажилтнууд эдийн засгийн мэдлэг олгох шаталсан сургалтыг зохион байгуулахын өмнө сургалтын агуулга, гарын авлагыг бэлтгэх нь чухал юм. Тухайлбал, сум, багийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Засаг дарга, Засаг Даргын Тамгын Газрын дарга болон түшмэлүүдэд дараахь сургалтыг шатлан оруулах нь зүйтэй юм. Үүнд:

- a. Сумын нийгэм, эдийн засгийн төлөвлөлт хийх аргачлал
- b. Суманд хадгаламж зээлийн хоршоо болон бичил санхүүгийн байгууллага байгуулах үндэслэл, хэрэгцээ
- c. Мал аж ахуйн даатгалын систем /цөм сүргийг даатгах/, түүнийг хөгжүүлэх асуудал
- d. Малчдад зээл олгох арга ажиллагаа, зээл ашиглах талаар зөвлөмж
- e. Монголын хоршоолол, хоршооны түүх, сургамж, хэтийн хандлага
- f. Зах зээлийн харилцааны үеийн хоршооллын зарчмууд, хэрэгжүүлэх арга зам
- g. Жижиг бизнесийн хамтын удирдлага
- h. Малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын суваг, Хүнс өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийн суваг, удирдлага

МГТЭ-ийн бэлтгэлийн ба зээл санхүүгийн бичил зах зээлийг сумын гадаад орчноос хамгаалж дотоод аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн өрсөлдөөнийг чөлөөтэй явуулах бодлого баримтлахад суралцах,

#### **Сургалтыг өргөжүүлэх талаар**

IV.3.2.3 Хоршоо болон хамтран ажиллаж байгаа бусад хэлбэрүүдийн давуу тал, ололт амжилтыг судлан бусдад түгээх, сул ажилласан нэгжүүдийн алдсан шалтгааныг шинжлэн бусад хоршоод алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Хоршооны үйл ажиллагаа эрхлэх, төсөл тооцоо хийх, удирдах талаар сэдэвчилсэн, шаталсан сургалтуудыг малчдын идэвхи санаачилгад тулгуурлан сум, багийн ИТХ, ЗДТГ-аас эрчимтэй явуулна.

**Төгсөв.**